



# ШИНЬ ШИНЬ ХХК

УЛААН, МУХАРЫН ОРДООС ХОЛИМОГ МЕТАЛЛ ОЛБОРЛОХ  
БАЯЖУУЛАХ ТӨСӨЛ

**ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР СУМЫН НУТАГТ  
БАЙРЛАХ УЛААН, МУХАРЫН ОРД ТӨСЛИЙН 2025  
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ДОРНОД АЙМАГ  
2025 ОН

ДОРНОД АЙМГИЙН ДАШБАЛБАР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ  
УЛААН, МУХАРЫН ОРД ТӨСӨЛ

## 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-000247/  
/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-00010089/

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТЕРИЙН ДУГААР 2830213/

### БИЕЛЭЛТИЙГ ГАРГАСАН:

“ШИНЬ ШИНЬ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  ГҮН МИН ШАНЬ

“ШИНЬ ШИНЬ ХХК”-ИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ  
МЭНД АЮУЛГҮЙ БАЙДАЛ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ХЭЛТСИЙН ДАРГА

 ВАН МИН ШАНЬ

“ШИНЬ ШИНЬ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЭРГЭЖИЛТЭН

 М.МӨНХТУУЛ

“ШИНЬ ШИНЬ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЭРГЭЖИЛТЭН

 Б. АМЬДРАЛ

2025 он


1.	Төслийн танилцуулга .....	2
1.1.	Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга .....	3
1.1.1.	Физик газарзүй.....	3
1.1.2.	Уур амьсгал.....	3
1.2.	Агаарын чанар .....	8
1.3.	Гадаргын болон газрын доорхи усны чанар .....	9
1.4.	Хөрсөн бүрхэвч .....	11
1.5.	Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт .....	12
1.6.	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ .....	15
2.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
2.1.	Агаар орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр.....	15
2.2.	Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр .....	16
2.3.	Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр .....	22
2.4.	Ургамлан нөмрөгийг хамгаалах чиглэлээр.....	24
2.5.	Физик нөлөөллийг бууруулах чиглэлээр .....	25
2.6.	Хүний эрүүл мэнд.....	25
3.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	25
4.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ.....	26
5.	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ .....	27
6.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ .....	27
7.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	27
7.1.	Химийн бодисын төрөл хэмжээ, хэрэглээ .....	27
7.2.	Тохиолдож болшгүй эрсдэл.....	28
7.3.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	28
7.3.1.	Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр .....	28
7.3.2.	Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр .....	30
7.3.3.	Химийн бодисын эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ .....	33
8.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	38
8.1.	Ахуйн хог хаягдлын арга хэмжээний төлөвлөгөө.....	38
8.2.	Аюултай хог хаягдлын арга хэмжээний төлөвлөгөө .....	39
8.3.	Бүх ангилалд .....	40
9.	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр.....	41
9.1.	Агаарын бохирдлыг хянах .....	41
9.2.	Усны бохирдлыг хянах .....	42
9.3.	Хөрсний бохирдлыг хянах .....	51
9.4.	Цацрагийн бохирдлыг хянах .....	54
9.5.	Ургамлан бүрхэвч.....	62
10.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	62
11.	Бомт, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	67
12.	Дүгнэлт.....	68

## 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улаан, Мухарын холимог металлын орд нь Монгол орны зүүн хойд хэсэгт х.ө. 49°05', з.у. 114°05' солбицолд байрлана. Орд нь Улаанбаатар хотоос зүүн хойд зүгт 790 км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос хойд зүгт 130 км, Дорнод аймгийн Дашбалбар сумын төвөөс баруун урд зүгт 70 км зайд оршино.

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших Улаан, Мухарын холимог металлын ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.

“Шинь Шинь” ХХК болон “Хунбөө” ХХК-ийн гүйцэтгэсэн олборлолтын мэдээллийг ашиглан нөөцийг шинэчлэн тооцоолж АМГТГ-н даргын 2018 оны 11-р сарын 05-ны өдрийн/115 тоот тушаалаар ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд үр ашигтай хүдрийн масс нийт 62.55 сая тонн гэж бүртгэсэн. Улааны ордын хүдрийн нийт нөөцийн 94.44% нь лицензтэй талбайнуудад хамаарагдаж байгаа бол 5.56% нь ашиглалтын талбайнуудын гадна үлдсэн ба “Шинь Шинь” ХХК-ийн эзэмшдэг MV-000247 тоот талбай дотор лицензтэй талбайнуудын үр ашигтай нийт нөөцийн 68.4%, “Хунбөө” ХХК-ийн MV-013555 тоот талбай дотор үр ашигтай нийт нөөцийн 31.% нь тус тус хамаарч байна.



Зураг 1. Төслийн байршил

## 1.1.ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1.1. ФИЗИК ГАЗАРЗҮЙ

Уурхайн орд газар нь нам уулс, ухаа гүвээ, толгодоор хүрээлэгдсэн, толгодын орой хяр нь бөөрөнхий хавтгайдуу оройтой, уулын ар хажуу нь нилээд огцом, эдгээрийн хооронд нарийвтар хөндийнүүдтэй байна. Уурхай орчмын газар нутаг нь физик газарзүйн мужлалтаар Монголын дорнод талын их мужийн Дорнодын тэгш талын мужийн Хэрлэнгийн хойд талын тойрогт багтана.

### 1.1.2. УУР АМЬСГАЛ

Дорнод аймгийн Дашбалбар сум орчмын уур амьсгалыг тодорхойлж, үнэлэх судалгааны ажлын хүрээнд цаг уурын Дашбалбар станцын 2010-2022 оны мэдээг ашигласан болно. /Эх сурвалж: Цаг Уур Орчны Шинжилгээний Газар, Архив Мэдээллийн Сангийн хэлтэс/


#### *Агаарын температур*

Агаарын сарын дундаж температурын агууриг  $41.4^{\circ}\text{C}$  байна. Үнэмлэхүй агууриг нь  $45.2^{\circ}\text{C}$  хүрдэг байна. Агаарын температур тодорхой илэрсэн жил, хоногийн явцтай байдаг. Жилийн явцад агаарын температурын их утга нь зуны 7 дугаар сард, бага утга нь өвөл 1 дүгээр сард тус тус ажиглагддаг байна. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын температур  $+20.4^{\circ}\text{C}$  хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур  $-20.6^{\circ}\text{C}$  байна. Агаарын үнэмлэхүй хамгийн их температур 2016 оны 8 дугаар сард  $+41.4^{\circ}\text{C}$  хүрч дулаарсан бол үнэмлэхүй хамгийн бага температур 2012 оны 01 дүгээр сард  $-41.7^{\circ}\text{C}$  хүрч хүйтэрсэн байна.

Үйл ажиллагаа явуулж буй талбай орчмын агаарын температурыг Дашбалбар станцын 2010-2022 оны мэдээнд тулгуурлан зураг 2, 3-т үзүүлээ.



Зураг 2. Жилийн дундаж агаарын температурын явц /Дашбалбар сум 2010-2022/




Зураг 3. Сарын дундаж агаарын температурын явц /Дашбалбар сум 2010-2022/


### Хөрсний гадаргын температур

Хөрсний гадаргын сарын дундаж температурын агууриг 48.3°C байна. Үнэмлэхүй агууриг нь 53.7°C хүрдэг байна. Жилийн явцад хөрсний гадаргын температурын их утга нь зуны 7 дугаар сард, бага утга нь өвөл 1 дүгээр сард тус тус ажиглагддаг байна. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж хөрсний температур +25.2°C хамгийн хүйтэн 1 дүгээр сарын хөрсний гадаргын дундаж температур -22.7°C байна.

Үйл ажиллагаа явуулж буй талбай орчмын хөрсний гадаргын температурыг Дашбалбар станцын 2010-2022 оны мэдээнд тулгуурлан зураг 4, 5-т үзүүллээ.



Зураг 4. Жилийн дундаж хөрсний гадаргын температурын явц /Дашбалбар сум 2010- 2022/



Зураг 5. Сарын дундаж хөрсний гадаргын температурын явц /Дашибалбар сум 2010- 2022/  
**Хур тунадас**

Тухайн бүс нутагт жилдээ дундажаар 301.1 мм хур тунадас ордог байна. Уур амьсгалын дулааралт, хуурайшилтын үйл явц сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц илэрч байна. 2010-2022 онуудад тус аймагт 137.9-520.2 мм тунадас унасан байна. Жилд орох хур тунадасны дийлэнх хувь нь зуны улиралд буюу 7, 8, 9-р саруудад ордог байна.

Жилд орох хур тунадасны нийлбэр хэмжээг 2015-2024 онуудын мэдээнд үндэслэн зураг 6, 7-д үзүүллээ.



Зураг 6. Нийлбэр хур тунадас /2015-2024/



Зураг 7. Хур тунадасны сарын хуваарилалт /2014-2024/

Хур тунадасны жилийн нийлбэрийн сүүлийн жилүүдийн өөрчлөлтийг авч үзэхэд төсөл хэрэгжих талбайн орчмоор сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байгаа ба 2020 онд 496.5 мм, 2021 онд 520.2 мм тунадас унасан байна.

**Агаарын чийгшил**

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт жилийн дундаж харьцангуй чийгшил 64.1% байна. Харьцангуй чийгшил 1 дүгээр сард хамгийн их утгатай 72.7%, 4 дүгээр сард хамгийн бага утгатай 45.8% болно.



Зураг 8. Харьцангуй чийгшилийн жилийн явц (Дашбалбар станц, 2013-2022)



Зураг 9. Харьцангуй чийгшилийн сарын явц (Дашибалбар станц, 2010-2022)

### Салхи

Дорнод аймаг нь хээрийн бүсэд хамаарагдах ба нөмөрлөж хаах уул, нуруу ховор учраас салхитай нутагт хамаарагдана. Гэхдээ хүчтэй шуургалж салхилах нь ховор. Олон жилийн дунджаас үзэхэд салхигүй намуун үе нийт ажиглалтын 19.2 хувьд байдаг байна. Салхины зонхилох чиглэл баруун ба баруун хойд талаасаа байдаг.



Зураг 10. Салхины дундаж хурдны жилийн явц /2015-2024 он/



Зураг 11. Салхины дундаж хурдны сарын явц /2010-2024 он/



Зураг 12. Сүүлийн жилүүдэд ажиглагдсан салхины чиглэлийн давтагдал, % /2010-2022/

## 1.2. АГААРЫН ЧАНАР

Төслийн орчинд өнгөрсөн 14 жилийн хугацаанд агаарын бохирдлын хэмжилтийг тогтмол хийсэн дараах 8 цэг байна. Төслийн БОМТ-ний биелэлтийн тайлан болон хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд агаарын бохирдлын хяналт мониторингийн 12 цэгт ажиглалт, судалгаа хийж сөрөг нөлөөллийг хянадаг. Харин тодорхой үе шатуудаар хийдэг байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангуудад агаар бохирдуулагчийн хэмжилтүүдийг 9-11 цэгт хийж ирсэн байдаг.

Агаарын дотоод орчны хэмжилтийг эрүүл ахуйн мэргэжилтнүүд, гадаад орчны хэмжилтийг байгаль орчны мэргэжилтнүүд гардаж хийдэг байна.

2020-2024 онуудад агаар бохирдуулагчид төслийн хүрээнд хийсэн судалгаагаар агаар дахь бохирдуулагчийн тархалт, нягтшил нь MNS 4585:2016 стандартын хүлцэх хэмжээнээс давсан тохиолдолгүй байна.


Хүснэгт 1. Төслийн бүс нутгийн агаар дахь бохирдуулагчийн тархалт, түүний хэлбэлзэл

№	Агаар бохирдуулагчид	Агаар дахь тархалтын өөрчлөлтийн зураг
1	Агаар дахь тоосны тархалт нь төслийн бүс нутагт 168 мгр/м <sup>3</sup> хүртэл тархалттай байгаа нь их тархалттай үедээ MNS 4585:2016 стандартын хүлцэх хэмжээнээс 3.8 дахин, бага тархалттай үедээ 500.0 дахин бага байна.	<p>Агаар дахь тоосны тархалтын динамик өөрчлөлт, жилүүдээр</p>
2	Агаар дахь хүхэрлэг хийн тархалт нь төслийн бүс нутагт 197 мгр/м <sup>3</sup> хүртэл тархалттай байгаа нь MNS 4585:2016 стандартын хүлцэх хэмжээнээс их тархалттай үедээ 2.3 дахин, бага тархалттай үедээ 450.0 дахин бага байна.	<p>Агаар дахь хүхэрлэг хийн тархалтын динамик өөрчлөлт, 2020-2024</p>
3	Агаар дахь азотын давхар ислийн тархалт нь төслийн бүс нутагт 62 мгр/м <sup>3</sup> хүртэл тархалттай байгаа нь MNS 4585:2016 стандартын хүлцэх хэмжээнээс их тархалттай үедээ 3.3 дахин, бага тархалттай үедээ 22.2 дахин бага байна.	<p>Агаар дахь азотын давхар ислийн агууламжийн динамик өөрчлөлт, 2020-24</p>

Эндээс төслийн хэрэгжилтийн 9-14 дэх жилд агаар дахь бохирдуулагчийн тархалт сүүлийн 5 жилийн үзүүлэлтээр стандартын хүлцэх хэмжээнээс хамгийн багадаа 3.3 дахин бага үзүүлэлтээр тогтворжсон гэж үзэж болно.

### 1.3.ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХИ УСНЫ ЧАНАР

Монгол орны гол, мөрөн, түүний сав газрын хэмжээ, байгалийн нөхцөл, урсац бүрэлдэх зүй тогтол, нөөцийн хуваарьлалт, байгалийн болон засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 332 дугаар тушаалаар Монгол орны нутаг дэвсгэрийг усны 29 сав газарт хувааж, хил хязгаарыг нь тогтоож өгсөн байдаг бөгөөд тус төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Улз голын сав газарт хамаарна. Улз голын сав газрын байршлыг дараах зургаар харуулав.



Зураг 13. Улз голын сав газар

Улз голын сав газар нь Монгол орны зүүн хойд хэсэгт орших Дорнодын талд ойролцоогоор 38,000 км<sup>2</sup>-ыг эзлэн Хэнтийн аймгийн Норовлин, Батноров, Дадал, Баян-Адарга сумд болон Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Гурванзагал, Чойбалсан, Сэргэлэн, Чулуунхороот зэрэг нийт 11 сумын нутаг дэвсгэрийг дамнан оршдог. Улз голын сав газрын 89.8 хувийг Дорнод, 7.4 хувийг Хэнтий аймаг, 2.8 хувийг ОХУ-ын, мөн багагүй хэсгийг БНХАУ-ын нутаг дэвсгэрийг хамарч тогтсон байна.

Төслийн талбайн орд гарын доорх ус нь Дөрөвдөгчийн уст бүрдэл (alQIV) , Доод Цэрдийн Зүүнбаянгийн тунамал чулуулагт агуулагдах уст давхаргаас бүрддэг.

Төслийн хэмжээнд унд ахуй, баяжуулах үйлдвэр, далд уурхайд төслийн нийт хугацаанд 18.04 сая.м<sup>3</sup> ус зарцуулах буюу хоногт 2143 м<sup>3</sup> ус ашиглагдахаар байна. Дээр дурдсанчлан Сосновын экспедицийн гидрогеологийн ангийн Сэвсүүлийн голын хөндийд тогтоосон газар доорх усны ордын нөөц нь үйлдвэрлэлийн зэргээр (A+B+C1) 17885м<sup>3</sup>/хон буюу 207м<sup>3</sup>/цаг байх ба чанарын хувьд ундны усны стандартыг бүрэн хангасан байна. Иймд Улааны уурхайг иж бүрэн ашиглах төсөлд тооцсон хоногт 2143 м<sup>3</sup> усыг бүрэн хангах чадамжтай байна.

Сэвсүүлийн голын хөндий нь геологи-гидрогеологийн янз бүрийн түвшний судалгаанд хамрагдсан, газрын доорх усны ордын ашиглалт явагдаж байсан талбай юм. Тухайлбал, 1980-1984 онд В.А.Манукян, Е.Ф.Гаркушин, А.М.Таболлина нар ус хангамжийн 2289 тоот даалгаврын дагуу ус хэрэглэгчээс 50 км радиус талбайд ус хангамжийн эх үүсвэр илрүүлэхээр Улз, Сэвсүүл, Мардайн голын хөндийд гидрогеологийн судалгаа явуулсан. Уг судалгааны ажлыг 1980-1982 онд эрлийн шатны ажлаар эхлүүлсэн бөгөөд 50 км радиус бүхий 16,238 кв.км талбайд геологи-гидрогеологийн нөхцөлийг судалжээ. Гидрогеологийн урьдчилсан хайгуулын ажил 1983 оны 1-р сараас 1984 оны 6-р сарын хугацаанд хийгдсэн

байна. Судалгааны ажлын цар хүрээ маш өргөн хэмжээнд хийгдсэн бөгөөд өрөмдлөг, шавхалт, болон гидрохимийн лабораторын ажлууд иж бүрнээр хийгджээ. Судалгааны үр дүнд Сэвсүүлийн голын хөндийг 2 хэсэгт хувааж нэгдүгээр хэсэн буюу Ногоон бүрдийн хэсэгт ашиглалтын нөөцийг В+С1 зэргээр 75 л/с буюу 6480 м3/хон, 2-р хэсэг буюу доод хэсгээс ашиглалтын В+С1 зэргээр 225 л/с буюу 19440 м3/хон гэж тогтоожээ.

#### 1.4.ХӨРСӨН БҮРХЭВЧ

Улааны уурхай орчмын газар нутаг нь физик газарзүйн мужлалаар Монголын дорнод талын их мужын Дорнодын тэгш талын мужын Хэрлэнгийн хойд талын тойрогт багтана. Газрын гадаргын хувьд Дорнодын тал нутаг нь хуурайсаг өндөрлөг хээрийн ерөнхий хэв шинжтэй. Тус нутаг дэвсгэр нь олон зүйлийн өвс ургамал, ховорхон тохиолдох хус, нарс, бут сөөгт төгөл бүхий дугуй хэлбэрийн намхан толгод, алгуур намсч тал хөндий үргэлжилнэ. Тус нутаг дэвсгэр нь д.т.д 900-1071 м-т орших газрын гадаргын намаас дундаж орчим өндөршилтэй. Төслийн талбай орчмын хамгийн өндөр цэг нь төслийн талбайгаас урагш орших Мухар хөв уул д.т.д 1131.7 м өндөртэй байна.

Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч нь хээр бүхий экосистемтэй, хэрчигдэл ихтэй нам өндөр уулс бүхий газарт тогтворжсон, голлох буюу Хархүрэн хөрсний ерөнхий үржил шимийн түвшин дунд зэрэг, шимт хөрсний нөөц сайтай, хөрсний бүтцийн тогтворшилт дунд зэрэг буюу механик нөлөөллөөр амархан эвдэрч талхигдан тоосжилт үүсэх эрсдэл дунд зэрэг байна. Харин хөрсөн дэх хортой болон био идэвхт хүнд металлын суурь агууламж стандартын хүлцэх агууламжаас хэтэрсэн тохиолдол нь Си, Рb бөгөөд энэ нь холимог металлын орд учраас дээрх 2 металлын агууламж нь хүний нөлөөтэй бус байгалийн өөрийнх нь аномал (гажил) зүй тогтол юм. Харин бусад металлууд хэвийн түвшинд буюу хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байна. Талбайн хэмжээнд уурхайн нөлөөллөөр нийт лицензийн талбайн 1.3% орчим нь эвдрэл талхагдалд орсон байна. Гэхдээ үйл ажиллагаанд өртсөн бүх талбайн шимт хөрсийг зохих стандартын дагуу хуулж авч хадгалсан байна. Мөн зарим шимт хөрсний овоолгыг үржил шимийн доройтол болон салхи усны алдрал сарнилд орохоос сэргийлж ургамалжуулж био хамгаалалт хийсэн байна.



Зураг 14 . Төслийн талбайн төрх

## 1.5. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ


Төслийн үйл ажиллагааны хүрээнд нөлөөлөлд нийт 1,360.0 га талбай их, бага ямар нэг хэмжээгээр өртөхөөр байгаа нь 2020 онд тодорхойлогдсон нөлөөллийн цар хүрээнээс 95.2 хувиар тэлсэн байдалтай байна. Энэ нь нэг талаас ашиглалтын 3 талбайг нийлүүлэн нэг төсөл болгож багатай холбоотойгоор ийм тэлэлт тодорхойлогдож байж болно.

Төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх нийт талбайн 349.6 га нь нөлөөллийн их эрчимтэй бүс болно гэж тодорхойлогдож байгаагийн 122.03 га нь эвдрэлд, тахлагдах зэрэг шууд нөлөөлөлд өртсөн гэж тодорхойлсон болно. Тиймээс тайлангийн зургаадугаар бүлэгт хөрс, ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг шууд нөлөөлөлд өртсөн гэж тодорхойлогдсон 122.03 га талбайд тооцсон болохыг энд тэмдэглэж байна.

Мөн хамгийн их эрчимтэй нөлөөллийн тэлэлт төслийн тусгай зөвшөөрлүүдийн талбайг бүхэлд хамарч байгаа байдалтай ба нөлөөллийн дунд зэргийн бүсэд 127.0 га, бага зэргийн бүсэд 579.0 га талбай хамрагдах нөхцөлтэй байна.

Хүснэгт 2. Төслийн нөлөөллийн цар хүрээ, түүний тэлэлт

№	Нөлөөллийн бүсийн эрчим	Нөлөөллийн бүсүүд		Нөлөөллийн бүсийн тэлэлт	
		2020 он	2024 он	Га-аар	%-аар
1	Их үйлчлэлтэй бүс	229,41	579.0	349.6	152.4
2	Дунд үйлчлэлтэй бүс	100.69	127.0	26.3	26.1
3	Бага үйлчлэлтэй бүс	366.64	579.0	212.4	57.9
<b>Нөлөөллийн нийт бүс</b>		<b>696.74</b>	<b>1,360.0</b>	<b>663.3</b>	<b>95.2</b>



Зураг 15. Төслийн үйл ажиллагаанаас газарт үзүүлэх нөлөөллийн цар хүрээ, ангилал, эрчим

Нөлөөллийн бүсийн хувьд 12.62% нь Дорнод аймгийн Баяндун суманд, 87.38 % нь Дорнод аймгийн Дашбалбар суманд хамаарна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг нийт 79 үзүүлэлтээр үнэлэхэд нийт үзүүлэлтүүдийн 38.0 хувь нь сөрөг, 21.5 хувь нь эерэг төлөвтэйгөөр нөлөөлж байхад 30.4 хувь нь хэвийн буюу төслийн хэрэгжилтийн өнгөрсөн хугацаанд тогтворжсон байна. Харин 10.1 хувь нь эрсдэлтэй гэж тодорхойлогджээ.

Хүснэгт 3. Төслийн үйл ажиллагаанаас үүсч буй нөлөөллийн төлөвийн ангилал

№	Байгаль орчны бүрдэл хэсэг	Нийт үзүүлэлт	Үүнээс:				
			Сөрөг	Эерэг	Хэвийн	Эрсдэлтэй	
1	Газар, газрын хэвлийд үзүүлсэн нөлөө	21	5	4	6	6	
2	Агаар орчинд үзүүлсэн нөлөө	14	5	5	4		
3	Усны орчинд үзүүлэх нөлөө	17	9	3	4	1	
4	Хөрс, ургамлан нөмрөг	11	6	1	3	1	
5	Зүйлийн олон янз байдалд үзүүлсэн нөлөө	16	5	4	7		
<b>НИЙТ</b>		<b>79</b>	<b>30</b>	<b>17</b>	<b>24</b>	<b>8</b>	
		тоо					
		хувь	100	38.0	21.5	30.4	10.1

Эндээс үзвэл цаашид төслийн үйл ажиллагаанаас үүссэн 30 үзүүлэлт бүхий сөрөг нөлөөг хүчин зүйлийн балл онооны аргаар үнэлэх, 8 үзүүлэлт бүхий эрсдэлтэй нөлөөг эрсдэлийн үнэлгээний аргаар тус тус үнэлэх шаардлагатай болж байна.



Зураг 16. Төслийн нөлөөллийн бүтэц

Мөн төслийн үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийн 16.0 хувь нь газар болон газрын хэвлийд, 30.0 хувь нь усны орчинд, 17.0 хувь нь зүйлийн олон янз байдалд, 17.0 хувь нь агаар, орчны чанарт, 20.0 хувь нь хөрс, ургамлын нөмрөгт тус тус нөлөөлнө.



Зураг 17. Төслөөс байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийн бүтэц

Төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн дүн шинжилгээ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх 35 үзүүлэлт бүхий сөрөг нөлөөг хүчин зүйлийн аргаар үнэлснээс үзвэл:

- 3 хүртэл оноо буюу маш бага эрчимтэй
- 9 нь 4-7 оноо буюу бага эрчимтэй
- 8 нь нь 8-11 оноо буюу дунд зэрэг эрчимтэй
- 16 нь 12-20 оноо буюу их эрчимтэй байж
- 20-оос олон оноо маш их эрчмийн үнэлгээ үнэлэгдсэнгүй.



Зураг 18. Төслийн сөрөг нөлөөллийн эрчим

## 1.6. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших “Шинь Шинь” ХХК-ийн MV-010089 /Мухарын холимог металын орд/, MV-000247/Улааны холимог металын орд/, “Хунбөө” ХХК-ийн MV-013555/Мухар-1 холимог металын орд/ тоот тусгай зөвшөөрөлтэй холимог металын хүдрийг далд уурхайн аргаар олборлох, баяжуулах төслийн ашиглалтын 5 жилийн БОМТ-г Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” баримтлан боловсруулсан болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн XII сарын 10-ны дотор тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 2.1. АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.1.1. Хатуу хучилтгүй зам дээрх тээврийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулахаар дулааны улиралд услах, дагтаршуулах ажлыг зохион байгуулдаг. Дотоод тэвээрлэлтийн зам, хүдрийн овоолгын талбайд усалгааны хууварийн дагуу 1576 шоо/метр усаар усалгаа хийсэн байна. 2025 оны ус ашиглуулах дүгнэлтийн дагуу зам талбайн тоосжилт дарах усалгаанд газрын доорх усны нөөц ашигласны төлбөрийг сар бүрийн тоолуурын бичилтэд тусгаж, харьяалагдах татварын албанд төвлөрүүлдэг.
- 2.1.2. Хүдрийн овоолгоос үүсэх тоосжилтын тархалтын хүрээг багасгахаар 3 метр өндөртэй, 129 метр урттайгаар салхины хаалт байгуулсан. Энэхүү хаалт нь агаарын урсгалын хурдыг багасгаж, үүний үр дүнд овоолгоос агаарт дэгдэх тоосжилт буурна.
- 2.1.3. Үйлдвэрлэлийн туслах хэлтсийн 2 ээлжийн жолооч нарт болон туслан гүйцэтгэгч аж ахуй нэгж байгууллагын ажилтнуудад тээврийн хэрэгслийн асаалттай үеийн хор нөлөөллийн мэдээллийг танилцуулсан. Мөн мэдээллийн самбаруудад болон цахим хуудсанд байрлуулсан.

2.1.4. SKC Airchek Essentail pump kit загварын агаарын тоос, хорт бодисын сорьц цуглуулах багажаар хөдөлмөрийн эрүүл ахуйн зориулалтаар цулцанд нэвтрэх тоосыг шинжлүүлдэг. Дээрх багажийг байгаль орчны бохирдлыг тодорхойлохоор ашиглах боломжтой тул сорьц цуглуулж, лабораторийн шинжилгээ хийлгэхээр “Эрүүл ахуй, хор судлалын лаборатори” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээний дагуу гадаад болон дотоод орчинд нийт 16 агаарын сорьц авч, нийт тоосонцорын шинжилгээ хийлгэхээр лаборатори луу илгээгээд байна.

## 2.2.ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХИ УСАНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

### 2025 оны усны хэрэглээ, ашиглалт

#### *Усны эх үүсвэр, усны нөөц, ус ашиглалтын хууль эрх зүйн орчин*

Улаан, Мухарын холимог металлын уурхайн усан хангамжид зориулсан ус татах талбайд газрын доорхи усны ашиглалтын нөөцийг баталгаажуулах мөн Монгол улсын засгийн газрын 2014 оны 12 дугаар тогтоолоор “Улсын төсвийн хөрөнгөөр судалж тогтоосон газрын доорх усны нөөцийн эрэл, хайгуул судалгааны зардлыг ус ашиглагчаар эргүүлэн төлөх журам”-ын дагуу Сэвсүүлийн голын Ногоон бүрдийн талд 2014-2015 онд судалгааны ажлыг гүйцэтгүүлсэн.

Улаан, Мухарын холимог металлын уурхайн баяжуулах үйлдвэрт шаардагдах боломжит нөөцийн дүгнэлтийг 2015 оны 09-р сарын 28-ны 08/5418 тоот Байгаль орчин, ногоон хөгжлийн ямаар гаргуулж мөн 2015 оны 08-р сарын 20-ны 08/6039 тоот ордын нөхөн төлбөрийн дүгнэлт гаргуулсан. Уг дүгнэлтийн дагуу Монгол-Ус ТӨҮГазартай 5 жилийн хугацаатай гэрээ байгуулан улсын төсвийн хөрөнгөөр судалж тогтоосон газрын усны нөөцийн эрэл, хайгуул зардлыг төлж барагдуулсан.

Гүний хоолойн ус татах байгууламж нь 9 худаг, 2 ус өргөх станц, нэг бүр 300, 300, 500, 900,1500,1500 шоо метр багтаамжтай 6 ширхэг ус харимтлуулах сантай. Цэвэр ус дамжуулах шугам хоолой 7000м урттай Ш500 PVC хоолой 11000м урттай Ш500 ган хоолой нийт 18000м хоолойгоор цэвэр ус дамжуулдаг.



Зураг 19. Усны эх үүсвэрүүд

Улаан, Мухарын холимог металлын уурхайн усны хэрэгцээнд нийт гүний 9 худгийг унд ахуй, баяжуулах үйлдвэр, дүүргэлтийн цех, уурын зуух-дулаан үйлдвэрлэл, ногоон байгууламжийн хэрэгцээнд ашигладаг. Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-т тус тус заасны дагуу, Усны газрын 2025 оны 05-р сарын 14-ний өдрийн Е-2504-000142 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Онон-Улз голын сав газрын захиргаанаас олгосон 2025 оны 05-р сарын 19-ний №А/05 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн Онон-Улз голын сав газрын

захиргаатай 2025 оны 05-р сарын 19-ны өдрийн 03 дугаартай ус ашиглуулах гэрээг нэг жилийн хугацаатайгаар байгуулсан.

“Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” Монгол Улсмын Засгийн газрын 2013 оны 09-р сарын 21-ний өдрийн 326 тоот тогтоол, Засгийн газрын 2011 оны 10-р сарын 26-ны өдрийн 302 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр”-т өөрчлөлт оруулах тухай 2013 оны 09-р сарын 21-ны өдрийн 327 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ус ашиглалтын төлбөрийг тооцож барагдуулсан. Эдгээр тогтоолын дагуу ус ашиглах зориулалтыг дараах байдлаар ангилсан бөгөөд төлбөрийн хувь хэмжээ өөр өөр байна.

Хүснэгт 4. Ус ашиглалтын төлбөрийн хэмжээ

Төлбөр ноогдох ус		Төлбөрийн хувь/ экологи эдийн засгийн үнэлгээний хувиар/	Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр	Ноогдох усы төлбөр м <sup>3</sup> /төг
1	Баяжуулах үйлдвэр	35	1.4	1362.2
2	Далд уурхайн шавхалтын ус	15	1.2	500.4
3	Унд-ахуйн хэрэгцээнд			1500
4	Гоосжилтын эсрэг зам талбайн усалгаа			166.8
5	Ногоон байгууламжийн усалгаа	10	0.25	69.5
6	Уурын зуух-дулаан үйлдвэрлэл	15	0.15	62.55

Ус ашигласны төлбөрийн хэмжээг усны эх үүсвэрт буюу гүн өрмийн худагт байрлуулсан усны тоолуурын заалтын зөрүүг үндэслэн баталгаажуулж, тухайн сарын 24-ний өдөр Дашбалбар сумын байгаль хамгаалагчид хянуулдаг.

Төслийн хэмжээнд ашиглаж буй худгуудад хэмжил зүйн баталгаажуулалт бүхий усны тоолуурыг суурилуулан ашигладаг.

Хүснэгт 5. Усны тоолуурын баталгаажуулалт хийсэн мэдээлэл

Тоолуурын байршил	Марк, серийн дугаар	Диаметр	Тоолуур үйлдвэрлэгч	Баталгаажуулалт хийсэн огноо	Дуусах хугацаа	Ашиглалтын зориулалт
Худаг 1	1609027998	150	БНХАУ	2023.11.29	2025.11.29	Мөнгөн тооцоо
Худаг 2	202300907	150	БНХАУ	2024.03.18	2026.03.18	Мөнгөн тооцоо
Худаг 3	1704000033	150	БНХАУ	2023.11.29	2025.11.29	Мөнгөн тооцоо
Худаг 4	2406022238	150	БНХАУ	2024.07.29	2026.07.29	Мөнгөн тооцоо
Худаг 5	2406022240	150	БНХАУ	2024.07.29	2026.07.29	Мөнгөн тооцоо
Худаг 6	20230091	150	БНХАУ	2024.04.26	2026.04.26	Мөнгөн тооцоо
Худаг 7	202300912	150	БНХАУ	2024.04.26	2026.04.26	Мөнгөн тооцоо
Худаг 8	2406022227	150	БНХАУ	2024.07.29	2026.07.29	Мөнгөн тооцоо
Худаг 9	202300910	150	БНХАУ	2024.04.26	2026.04.26	Мөнгөн тооцоо
Далд уурхайн шавхалтын шугам гадна	2406022213	100	БНХАУ	2024.07.29	2026.07.29	Мөнгөн тооцоо
Далд уурхайн шавхалтын шугам дотор	202304274	100	БНХАУ	2023.11.17	2025.11.17	Мөнгөн тооцоо

Буцах усан сангийн насос	2104000659	80	БНХАУ	2023.11.13	2025.11.13	Мөнгөн тооцоо
Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж	2107000804	65	БНХАУ	2023.11.13	2025.11.13	Мөнгөн тооцоо
Дүүргэлт цех	2406022202	100	БНХАУ	2024.07.29	2026.07.29	Мөнгөн тооцоо

## 2025 оны ус ашиглалт, төлбөр тооцоо

Баяжуулах үйлдвэр уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажиллаж, 2025 оны 10-р сарын байдлаар 323,473.76 шоо/метр усыг технологийн хэрэгцээнд нөхөн сэлбэлтээр ашигласан. Технологийн хэрэгцээнд нөхөн сэлбэлтээр ашигласан усны хэрэглээг сар бүрээр доорх графикт харуулав.



График 1. Улаан, Мухарын орд төслийн нөхөн сэлбэлтээр ашигласан ус

Хүснэгт 6. Төслийн үйл ажиллагааны ус ашиглалтын мэдээ  
(ашиглалтын худгуудын баталгаат усны тоолуурын заалтаар тооцсон)

№	Зориулалт	Ашигласан усны хэмжээ шоо/метр	Тайлбар
1	Баяжуулах үйлдвэр	323,473.76	
2	Унд-ахуй	36,000	
3	Далд уурхайн шавхалтын ус	177,442	Стандарт хэмжилзүйн баталгаажсан тоолуураар тооцов. Усыг баяжуулах үйлдвэрт ашигласан.
4	Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж	26,448	
5	Ууурын зуух-дулаан үйлдвэрлэл	3,000	
6	Тоосжилтын эсрэг зам талбайн усалгаа	1,576	
7	Ногоон байгууламжийн усалгаа	636.84	
	Нийт		

2024 оны 12-р сарын 24-нөөс 2025 оны 10-р сарын 24-ний өдрийн байдлаар төслийн хэмжээнд ус ашигласны нийт төлбөр 583,659,912.55 (Таван зуун наян гурван сая зургаан

зуун тавин есөн мянга есөн зуун арван хоёр төгрөг тавин таван мөнгө) ноогдуулснаас 2025 оны 10 сарын 24-ний байдлаар 583,659,912.55 (Таван зуун наян гурван сая зургаан зуун тавин есөн мянга есөн зуун арван хоёр төгрөг тавин таван мөнгө) төгрөгийг Дорнод аймаг болон Дашбалбар сумын төсөвт төвлөрүүлээд байна.

Хүснэгт 7. 2025 оны ус ашиглалтын төлбөрийн гүйцэтгэл

2025 он	Төлбөрийн нэхэмжлэл /төг/	Төлбөрийн гүйцэтгэл /төг/	Тайлбар
1-р сар	74,850,821.80	74,850,821.80	Дансаар төлсөн, усны тоолуурын бичилт, төлбөр төлсөн баримтыг хавсралтаар харуулав.
2-р сар	74,964,301.40	74,964,301.40	
3-р сар	50,109,266.60	50,109,266.60	
4-р сар	45,317,047	45,317,047	
5-р сар	49,007,469.20	49,007,469.20	
6-р сар	60,491,593.60	60,491,593.60	
7-р сар	55,844,128.60	55,844,128.60	
8-р сар	54,826,109.28	54,826,109.28	
9-р сар	51,306,039.92	51,306,039.92	
10-р сар	66,943,135.15	66,943,135.15	
Нийт	583,659,912.55	583,659,912.55	

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан 2025 оны 03-р сарын 18-ны өдөр Онон-Улз голын сав газрын захиргааны дарга болон мэргэжилтнүүд уурхайн бүсэд ирж, сургалт болон асуулт хариултын тэмцээн зохион байгуулсан. Тухайн жилийн урианы хүрээнд “Мөсөн гол ба мөнх цэвдэг” сэдэвт сургалтад 48 ажилтан хамрагдсан.



Зураг 20. ОУГСГЗ-ны сургалт мэдээлэл

Мөн ус хангамжийн инженер байгаль орчны инженерүүд 03-р сард Дэлхийн усны өдөр, “Шинь Шинь “ ХХК-ийн ус ашиглалт, ус ашиглалтын зориулалт, төлбөр, усны эргэлт сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалтад 4-н ээлжийн нийт 313 ажилтан хамрагдсан.



Зураг 21. Дэлхийн усны өдрийн сургалт мэдээлэл

### Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн хяналт

Улаан, Мухарын уурхай нь ажилтнуудын унд ахуйгаас гарсан бохир усыг цэвэршүүлэх ионжуулагч цэвэрлэх байгууламжтай ба бохир усыг септик, бактерийн наалдац бүхий биологийн цэвэрлэгээ, хэт ягаан туяа гэсэн хэсгүүдээр дамжин цэвэрлэдэг. Мембран биореактор (MBR) –ын технологийр хоногт 150 шоо/метр ахуйн бохир усыг цэвэрлэх хүчин чадалтай.

Усны хяналт шинжилгээний ажлын хүрээнд улиралд 2-оос доошгүй удаа ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн оролт болон гаралтын хэсгээс дээжлэлт хийж, Дорнод аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лаборатори, УЦУОШТ-ийн лаборатори, Усны газрын лабораториуд шинжлүүлдэг. Шинжилгээний үр дүнг хүснэгт 8-д харуулав.



Зураг 22. АБУЦБ-ийн усны дээжлэлт

Хүснэгт 8. АБУЦБ-ийн усны шинжилгээний үр дүн

Дээж авсан цэг		АБУЦБ оролт		АБУЦБ гаралт				
Шинжилсэн үзүүлэлт		5-р сар	9-р сар	1-р сар	3-р сар	5-р сар	6-р сар	9-р сар
Усны орчин	6-9	8.4	8.02	7.65	8.09	7.99	7.54	8.12
Умбуур бодис	400	102	208	15	2	3	6	50.4
Химийн хэрэгцээт хүчилтөрөгч	400	631.5		66.1	109.2	44.6	74.1	

<b>Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч</b>	<b>800</b>	242.88		25.42	42	29.84	28.5	
--	------------	--------	--	-------	----	-------	------	--

Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн усыг байгальд нийлүүлэхгүйгээр баяжуулах үйлдвэрийн технологид эргүүлэн ашигладаг. 2024 оны 12-р сарын 24-өөс 2025 оны 10-р сарын 24-ний хүртэл 26,448 шоо/метр усыг баяжуулах үйлдвэрт нийлүүлсэн байна. Стандарт хэмжилзүйн газраар баталгаажуулсан тоолуурын заалтаар тооцов.

Ахуйн бохир цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөжийн үйл ажиллагаа, тоолуурын бүрэн бүтэн байдал, усны хэрэглээнд хяналт тавьдаг. Тайлант хугацаанд 10 удаагийн хяналтыг дотоод хяналтын хуудсын дагуу хийж гүйцэтгэсэн. Хяналтын явцад илэрсэн зөрчил, доголдлыг тухай бүрд нь арилгуулах арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавьсан болно.



Зураг 23. АБУЦБ-ийн хяналт

### Хаягдлын сангийн хяналт

Хаягдлын далангийн хяналтын цооногуудын бүрэн бүтэн байдлыг шалгаж, 10 хоног тутам хяналтын цооногийн хэмжилт хийж байна. Нийт 29 удаагийн хэмжилт хийж гүйцэтгэсэн.



Зураг 24. Хяналтын цооногийн хэмжилт

Хаягдлын сангаас үүсэх тоосжилтыг бууруулахаар далангийн өргөтгөл болон засварын ажил хийгдээгүй үед боороожуулагч төхөөрөмжөөр усалгаа хийж гүйцэтгэдэг. Усалгаа хийгдэх боломжгүй нөхцөлд тоосыг салхиар тархахаас сэргийлж хучилт хийдэг.



Зураг 25. Хаягдлын сангийн далангийн хучилт

- 2.2.1. Эрэгтэй, эмэгтэй халуун усны газрын шүршүүрүүд дунджаар 10-12 литр/мин ус гаралттай байсан. Нийт 10 ширхэг шүршүүрийг 10 литр/мин гаралттай шүршүүрээр сольж суурилуулсан.
- 2.2.2. Уурхайн үйл ажиллагаанаас үүсч буй хаягдал уснаас улиралд 2-оос доошгүй удаа дээжлэлт хийж, усны хяналт шинжилгээг тогтмол хийж гүйцэтгэдэг. Улирал бүр Усны газрын хяналт шинжилгээний хэлтэст холбогдох бичиг баримтуудыг бүрдүүлэн хүсэлт гаргадаг. Хүсэлтийн дагуу ирүүлсэн хаягдал усны дүгнэлтийн дагуу төлбөрийг төлж барагдуулдаг.

Хүснэгт 9. Хаягдал усны төлбөрийн мэдээлэл

№	Улирал	Дүгнэлтийн дугаар	Ус бохирдуулсны төлбөр
1	1-р улирал	Е-2504-000273	3,747,091.55
2	2-р улирал	Е-2507-000316	19,328,773.29
Нийт			23,075,864.84

- 2.2.3. 2025 оны 05-р сарын 19-ний №А/05 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн Онон-Улз голын сав газрын захиргаатай 2025 оны 05-р сарын 19-ны өдрийн 03 дугаартай ус ашиглуулах гэрээг нэг жилийн хугацаатайгаар байгуулсан. Гэрээнд тусгагдсан ажлыг сар бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг ба тухайн жилийн ус ашиглалтын тайланд тусгаж, хуулийн хугацаанд Онон-Улз голын сав газрын захиргаанд хүргүүлж, тухайн оны ус ашиглуулах гэрээг дүгнэдэг.
- 2.2.4. Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Дашбалбар сумын ЕБС-ийн “Гангар хун” эко клуб болон ЗДТГ-ын байгаль орчны тасагтай хамтран гар зургийн уралдаан, бүтээлийн уралдаан, илтгэлийн уралдаан зохион амжилттай байгуулсан. Уралдааны шагналын санг санхүүжүүлж, шагналт байрыг тодруулах, гардуулах үйл ажиллагаанд байгаль орчны инженерүүд оролцож, хамтран ажилласан.

### 2.3. ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.3.1. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл болон тоосжилтыг бууруулахаар хаягдлын сангийн далангийн налуу хэсэгт 2.3 га талбай мөн далд уурхайн амны гадна талбайн

0.4 га талбайг олон наст ургамлаар ургамалжуулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.

- 2.3.2. Улаан, Мухарын холимог металлын орд төслийн баяжмал тээвэрлэлтийн “Дорнын эрдэс” ХХК-ийн 21 тээврийн хэрэгслүүдэд GPS төхөөрөмж суурилуулсан байдаг. Тээврийн хэрэгслүүдийн замын хөдөлгөөнийг хянах болон аюулгүй байдлыг хянах боломжтой.
- 2.3.3. Дашбалбар сумын Засаг даргын захирамжаар баталсан газар ашиглах зориулалтын дагуу хог хаягдлын цэгийг байгуулан, тогтмол үйл ажиллагаа явуулдаг. Хог хаягдлын цэгт мал, амьтан нэвтрэхээс сэргийлж бүрэн хашаажуулж, камержуулсан. Хог хаягдлын цэг дээрх үйл ажиллагааг туслан гүйцэтгэгч аж ахуй нэгж байгууллага "Есүй Бэхи" ХХК нь хариуцан ажилладаг.
- 2.3.4. Уурхайн эдэлбэр талбайн хил хязгаарыг тогтоож суулгасан ашигт малтмалын MV000247A тоот тусгай зөвшөөрлийн 4 цэг, MV00010089A тоот тусгай зөвшөөрлийн 6 цэгийн шав тэмдэгийг засаж, шинэчилсэн.

### Хөрсний бохирдлыг арилгасан тухай

Ашиглалтаас гарсан автомашинаас тос масло асгарсан болон тээвэрлэлтийн машины чиргүүл унаж цемент асгарсан 3 тохиолдол гарсан. Холбогдох хэлтэс цехийн ажилтнуудын хамт асаралт үүссэн хэсгийг хусах, цэвэрлэх, бохирдсон хөрсийг битүүмжлэлтэй саванд хадгалах, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. Тухай бүр нь ажлын явцыг баримтжуулж, хөрсний бохирдлыг арилгасан тухай тайлан бэлтгэсэн.



Зураг 26. Хөрсөнд үүссэн бохирдлыг цэвэрлэж буй нь



Зураг 27. Хөрсөнд үүссэн бохирдлыг цэвэрлэж буй нь



Зураг 28. Бохирдсон хөрсний хадгалалт

## 2.4. УРГАМЛАН НӨМРӨГИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

2.4.1. Уурхайн тосгоны орчныг тохижуулах ажлын хүрээнд нэг наст болон олон наст ургамлыг 4345 м<sup>2</sup> талбайд тарилт хийж, тохижуулсан.

Хүснэгт 10. Тарилт хийсэн талбайн мэдээлэл

№	Байршил	Нэр, төрөл	Талбайн хэмжээ м <sup>2</sup>
1	Оффис баруун тал	Нэгт наст ургамал /хумсан цэцэг/	190
2	Буудлын зүүн болон баруун тал	Олон наст ургамал, нэгт наст ургамал /хумсан цэцэг/	1208
3	Бараа материалын агуулахын эргэн тойронд	Олон наст ургамал, нэгт наст ургамал /хумсан цэцэг/	109
5	Эмнэлэг болон жижиг оффис	Олон наст ургамал, нэгт наст ургамал	402
6	Гал тогоо	Олон наст ургамал, нэгт наст ургамал /хумсан цэцэг/	560
7	Хаягдал дугуйгаар хийсэн цэцгийн мандал	Нэг наст ургамал /хумсан цэцэг/	553
8	Лабораторийн баруун тал	Олон наст ургамал, нэгт наст ургамал /хумсан цэцэг/	817
9	Баяжуулах үйлдвэр	Нэг наст ургамал /хумсан цэцэг/	203
<b>Тохижилтын ажлын талбай хэмжээ</b>			<b>4042</b>
<b>Явган хүний замын хажуугаар хийгдсэн тариалалт</b>			
1	Цэцгийн мандал	Хумсан цэцэг	303
<b>Талбайн хэмжээ</b>			
<b>Нийт талбайн хэмжээ</b>			<b>4345</b>

2.4.2. Биологийн нөхөн сэргээлт, ургамалжуулах ажил хийхдээ төслийн БОННУ-ний тайлангийн ургамлан нөмрөгийн мэдээлэл болон байгаль орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт ажлын тайлангийн ургамлын мониторинг, бичиглэлийн үр дүнгийн ургамлын жагсаалтаас ургамлын зүйлийг тодорхойлж, үетэн 40% /саман ерхөг, өлөнгө, соргүй согоовор/, буурцагтан 60% /царгас, хүцэнгэ, хошоон, ботууль/ байхаар үрийн холимгоор тарилт хийсэн.

## 2.5.ФИЗИК НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

2.5.1. Нэг бүрийн хамгаалах хэрэгслийн олголтыг “Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олголт, ашиглалтын журам”-ын дагуу тогтмол олгодог. Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээгээр ажлын байрны дуу шуугиан зөвшөөрөгдөх хэмжээ /85 дБ/-ээс өндөр ажлын байранд ажиллагсад сонсголын эрхтэн хамгаалах чихний бөглөөг 1102 ширхэгийг олгосон байна. Чихэвч болон чихний бөглөөг олголт, хэрэглээнд нь хөдөлмөр хамгааллын инженерүүд нь өдөр тутам хяналт тавьж ажилладаг.

## 2.6.ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД

- 2.6.1. Жил бүр зохион байгуулагддаг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг “Хужирт Сод” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. 11-р сарын 13-18-ны өдрүүдэд уурхайн бүсэд “Шинь Шинь” ХХК-ийн 4 ээлжийн нийт ажилтанг хамруулж, зохион байгуулна.
- 2.6.2. “Хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох тухай журам”-ын дагуу 10 нэр төрлийн бүтээгдэхүүнийг улирлын онцлогоос хамааран олгодог. Уурхайн бүсэд ажиллаж буй нийт ажилтанд өдөрт нэг удаа дархлаажуулах нэмэлт бүтээгдэхүүнийг тогтмол олгож байна.

## 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ


3.1.1. 2024 онд хуучин Мардай тосгонд техникийн нөхөн сэргээлт хийсэн 1.5 га талбайд 05-р сарын 29-ний өдрөөс эхлэн 3 хоногийн хугацаанд биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. Биологийн нөхөн сэргээлт хийхдээ үетэн 40% /саман ерхөг, өлөнгө, соргүй согоовор/, буурцагтан 60% /царгас, хүцэнгэ, хошоон, ботууль/ байхаар үрийн холимгийг тариалсан. Тариалалтын дараах усалгааг тогтмол хийж гүйцэтгэсэн.



Зураг 29. Олон наст ургамал тариалалтын явц



Зураг 30. Тариалалтын дараах усалгаа



Зураг 31. Нөхөн сэргээлт хийсэн талбай

#### 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

- 4.1.1. Орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газарт идэвхтэн байгаль хамгаалагчаар Дашбалбар сумын Сэвсүүл Жараахай багийн иргэн Н.Наранмандахтай 2019 оны 11-р сарын 14-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн гэрээ байгуулан одоог хүртэл хамтран ажиллаж байна. Идэвхтэн байгаль хамгаалагч нь дүйцүүлэн хамгаалах талбай дахь булгуудын хашаа хаалтны бүрэн бүтэн байдал, тарвага нутагшуулсан газарт хяналт тавьж, сар бүр ажлын тайлан илгээдэг.
- 4.1.2. Ой хээрийн түймэр, үер ус бусад байгалийн гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, тохиолдсон үед авах арга хэмжээг таниулсан тараах материал бэлтгэж, 04 болон 10-р саруудад уурхайн бүсийн 20 малчин өрхөд мэдээлэл хүргэсэн. Байгалийн гамшгийн үед яаралтай мэдээлэх утасны дугаар бүхий 11 мэдээллийн самбаруудыг шинэчилсэн.
- 4.1.3. Идэвхтэн байгаль хамгаалагч нь ОНТХГ, өмнөх онуудад хашаалсан булгууд, тарвага нутагшуулсан газруудад эргүүл, хяналт хийх явцдаа ажиглагдсан амьтныг бүртгэлийн дэвтэрт бүртгэдэг. Сар бүрийн тайландаа амьтны бүртгэл, цаг агаарын нөхцөл байдлыг тусгаж ирүүлдэг.
- 4.1.4. 2021, 2023 онуудад Дааврын булагт, 2024 онд Зээгийн өвөрт нийт 150 толгой Монгол тарвагыг нутагшуулсан. Энэ онд “Дорнын талын өргөө” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан, гэрээний дагуу нутагшуулсан тарваганд тооллого, мониторингийн

ажлыг гүйцэтгүүлсэн. Энэ онд Дааврын булагт 32 мөндөл 9 тошинд, Зээг уулын өвөрт 16 мөндөл 4 тошинд байрлалтайгаар тоологдсон байна.

4.1.5. Дашбалбар сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу Мардай тосгоны дулааны шугам хоолойнд эвдэрсэн 11565.8 м<sup>2</sup> эзэлхүүнтэй, 8.1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. 09-р сарын 06-25-ны өдрүүдэд ухлага үүссэн газрын хажуу дахь овоолго үүссэн хөрс шороог ашиглаж булах, дүүргэлт хийх, налуулах болон тэгшлэх зэрэг үе шатуудын дагуу хийж гүйцэтгэсэн.

Нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхээс өмнө эвдрэлд өртсөн талбайн геодезийн хэмжилт, зураглал хийлгэхээр “Хануйн Цав” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээт компани нь нөхөн сэргээлт хийх талбайд ажиллаж хэмжилт, зураглалын ажлын тайланг хүлээн өгсөн.

## 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ

Төслийн үйл ажиллагаатай холбоотой айл нүүлгэн шилжүүлэх ажиллагаа хийгдэхгүй болно.

### 6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Төслийн үйл ажиллагаатай холбоотой түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ хийгдэхгүй болно.

## 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 7.1. ХИМИЙН БОДИСЫН ТӨРӨЛ ХЭМЖЭЭ, ХЭРЭГЛЭЭ

Улаан, Мухарын холимог металлын орд төслийн баяжуулах үйлдвэрт ашиглагдах 12 нэр төрөл бодисын Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, ашиглах 0000107 тоот тусгай зөвшөөрлийг 2025 оны 03-р сарын 31-ний өдөр, чанарын хэлтэст ашиглагдах 75 нэр төрөл бодисын Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, ашиглах 0000251 тоот тусгай зөвшөөрлийг 2025 оны 09-р сарын 01-ний өдөр авсан.

Баяжуулах үйлдвэрээс зүүн хойд зүгт 300 гаруй метрт байршилтай, 864.4 м<sup>2</sup> талбайтай, 5.5 м өндөртэй, бетон раман цугтамал бүхий нэг давхар тоосгон барилга бүхий химийн бодисын агуулахтай. Тус агуулах нь хойд, урд гэсэн хоёр аврах гарцтай. Нийт 8 ширхэг цахилгаан агааржуулалтын системтэй. Химийн бодис тус бүрээр хор аюулын лавлах мэдээллийн самбарыг байршуулж, ажилтны ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажилладаг. Баяжуулах үйлдвэрт ашиглагдах химийн бодисын хэрэглээг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 11. Химийн бодисын жилийн хэрэглээ

№	Нэршил	Химийн томьёо	Зориулалт	Зарцуулалт гр/тн	Жилд зарцуулах бодисын хэмжээ, кг
1	Натрийн сульфит	Na <sub>2</sub> SO <sub>3</sub>	Дарагч	600	720*000
2	Цайрын сульфат	ZnSO <sub>4</sub>	Идэвхижүүлэгч	800	690*000
3	Аэрофин 3418А	C <sub>4</sub> H <sub>9</sub> OCSSNa	Цуглуулагч	80	150*000
4	Аэрофлот 25	(C <sub>7</sub> H <sub>7</sub> O) <sub>2</sub> PSSH	Цуглуулагч	60	72*000
5	Зэсийн сульфат	CuSO <sub>4</sub>	Идэвхижүүлэгч	200	270*000
6	Азотын хүчил	HNO <sub>3</sub>			20*000
7	Давсны хүчил	HCl			20*000

8	Кониферолын тос	C10H17OH		27'000
---	-----------------	----------	--	--------

## 7.2.ТОХИОЛДОЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

“Шинь Шинь” ХХК нь баяжуулах үйлдвэр болон далд уурхайн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг 2025 онд “Гал түймэр судлаачдын холбоо” ТББ-аар хийж гүйцэтгүүлсэн.

2025 онд Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийлгүүлж Онцгой байдлын газраар батлуулан, хэрэгжүүлж ажиллаж байна.

## 7.3.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 7.3.1. БАЙГАЛИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.3.1.1.“Шинь Шинь” ХХК-ийн уурхайн бүсэд нийт 5 ширхэг дуут дохиолол суурилуулсан байдаг. “Гамшиг, ослын үеийн дуут дохиоллоор ажиллах журам”-ын дагуу сар бүрийн 05, 20-ны өдрүүдэд дохиоллын хэвийн ажиллагааг тогтмол шалгаж, болзошгүй аюулын үеийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.



Зураг 32. Дуут дохиоллын хэвийн ажиллагааг шалгах явц

Засгийн газрын 2011 оны 339-р тогтоолоор “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”-ын хүрээнд 03-р сарын 27-ны өдөр гамшгийн үеийн дуут дохиоллоор ажиллах дадлага сургуулилтийг зохион байгуулсан.



Зураг 33. Дуут дохиололор ажиллах дадлага сургуулилт

7.3.1.2.Ой, хээрийн гал түймэр болон объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах танхимын болон практик сургалтыг 03 болон 06-р сард “Есүй Бэхи” ХХК болон “Цагаан Сор” ХХК-иудтай хамтран зохион байгуулсан. Сургалтад “Шинь Шинь” ХХК-ийн хэлтэс цехүүд болон туслан гүйцэтгэгч аж ахуй нэгжийн 157 ажилтан хамрагдсан.



Зураг 34. Практик сургалт

7.3.1.3.Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын гидрант, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу уурхайн хэмжээнд бүх объектуудад байрлуулж бэлэн байдлыг хангаж 10-р сарын байдлаар 20 удаа хяналт хийсэн байна. Уурхайн бүсэд галын сараан 22 ширхэг, галын гидрант 96 ширхэг, галын хор 466 ширхэгийг тус тус байршуулан, шаардлагатай тохиолдолд сэлбэн байршуулж бэлэн байдлыг ханган ажиллаж байна.



Зураг 35. Гал түймрийн багаж хэрэгслийн шалгалт

7.3.1.4.Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хүрээнд 07-р сарын 02-ны өдөр баяжуулах үйлдвэрийн хаягдлын сангийн үерийн аюулын үед авах цогц арга хэмжээ дадлага сургуулилтыг зохион байгуулсан. Үер усны эрсдлээс урьдчилан сэргийлэх, шуурхай хариу арга хэмжээ авах, томилгоот орон тооны бус бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор “Шинь Шинь” ХХК-ийн 100 гаруй ажилтныг хамруулсан.



Зураг 36. Дадлага сургуулилт

### 7.3.2. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.3.2.1. Хөдөлмөр хамгааллын инженерүүд дүрэм, журмын хэрэгжилтэд өдөр тутам хөдөлмөр хамгааллын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг бүрэн, зөв хэрэглэсэн эсэх, ажилд гарахын өмнө ажлын өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсан эсэх, ажлын байрны анхан шатны хяналтыг хөтөлсөн зэрэг үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.

Зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд “Зөрчлийн хуудас бичих, ашиглах журам”-ын дагуу тухай бүр арга хэмжээ авч, гүйцэтгэж ажиллаж байна. Тайлант хугацаанд 4 удаа арга хэмжээ авч ажилласан байна.



Зураг 37. Өдөр тутмын хяналт шалгалт

7.3.2.2. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын А/130 тоот тушаал, MNS 4969:2000 стандартыг хангаж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, аюулгүй ажиллагааны зааварчилгаануудыг цаг тухай бүрт тогтмол хийж байна. Тайлант хугацаанд сургалтад хамрагдсан тоон үзүүлэлтийг хэлтэс цех, туслан гүйцэтгэгч аж ахуй нэгж байгууллага, сургалтын төрлөөр нэгтгэн, хүснэгтээр үзүүлэв. /2024.12.26-2025.10.25/

Хүснэгт 12. Сургалтын тоо мэдээ

№	Хэлтэс, цех	Урьдчилсан зааварчилгаа	Өөр ажлын байранд шилжсэн ажилтны сургалт	Давтан зааварчилгааны сургалт	Зочдын зааварчилгаа	Туслан гүйцэтгэгч компанийн сургалт	Нийт ажилтны сургалт	Нийт
1	Баяжуулах үйлдвэр оффис						11	<b>11</b>
2	Хөвүүлэх цех	3	1	18			204	<b>226</b>
3	Хагаах цех	2	2	6			213	<b>223</b>
4	Бутлах цех	7		1			160	<b>168</b>
5	Дүүргэлт цех	7		2			107	<b>116</b>
6	Засварын цех	5	1	1			80	<b>87</b>
7	Чанарын хэлтэс	4	1	8			123	<b>136</b>
8	МХТТ-ийн хэлтэс	4		4			50	<b>58</b>
9	Үйлдвэрлэлийн туслах хэлтэс	13	3	6			264	<b>286</b>
10	ХЭМАББО-ы хэлтэс	3		2			43	<b>48</b>
11	Хүний нөөцийн хэлтэс						52	<b>52</b>
12	БОЭТөв				22			<b>22</b>
13	"ТМКМ" ХХК							
14	"Ванчуг Цутгалт" ХХК					11		<b>11</b>
15	"Цагаан Сор" ХХК	3				28		<b>31</b>
16	"Есүй Бэхи" ХХК					12		<b>12</b>
17	"ХХЕМ" ХХК					10		<b>10</b>
18	Бусад	1			119		35	<b>155</b>
19	"Хөн Тун Жинь Чөн Инженеринг" ХХК	15				30		<b>45</b>
20	"Ти Эм Би Эн" ХХК					6		<b>6</b>
	<b>Нийт</b>	<b>67</b>	<b>8</b>	<b>48</b>	<b>141</b>	<b>97</b>	<b>1342</b>	<b>1703</b>



Зураг 38. Сургалтын үеэр

Нийт ажилтны сургалтыг 01-05-р саруудад 7 хоног бүр ХЭМАББО-ы хэлтсийн ХХ-ын инженер, байгаль орчны инженер, хөдөлмөрийн эрүүл ахуйн инженер, эмч нар Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны сайдын А/130 тоот тушаалын сэдвийн хүрээнд ХЭМАБ болон байгаль орчин, эрүүл мэндийн сургалтыг батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу уурхайн бүсэд зохион байгуулсан.

Тайлант хугацаанд сургалтад давхардсан тоогоор 1342 ажилтан хамрагдаж чанар 89.3 хувь, хамрагдалт 92 хувьтайгаар зохион байгуулагдсан.



Зураг 39. Нийт ажилтны сургалт

Мөн нийт ажилтны сургалтыг мэргэжлийн байгууллага буюу Дорнод аймгийн Политехник коллежийн мэргэжлийн багш нар 05-р сарын 02-30-ны хооронд 3 ээлжээр дараах сэдвийн хүрээнд зохион байгуулсан.

- ХАБЭА-н тухай хууль
- Ажлын байран дахь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлс, түүний төрлүүд, мэргэжлээс шалтгаалал өвчлөлүүд
- Хувцас, хамгаалах хэрэгсэл
- Аюул осолд өртсөн хүнд үзүүлэх анхан шатны тусламж
- Эрсдлийг илрүүлэх арилгах
- Үйлдвэрийн осолд хүргэдэг аюултай хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт

7.3.2.3. “Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олголт, ашиглалтын журам”-ын дагуу ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын тусгай хувцсыг дараах байдлаар олгосон байна. /2024.12.26-2025.10.25/

Хүснэгт 13. Ажлын хувцас олголт

№	Нэр төрөл	Тоо ширхэг
1	Ажлын хувцас /өмд цамц/	569
2	Ажлын цамц /ноосон/	466
3	Зуны хувцас /нимгэн/	448
4	Өвлийн ажлын хувцас /куртик,өмд/	80
5	Далд уурхайн хувцас	0
6	Ажлын халат	0
7	Комбинзон /засварын/	0

8	Ажлын гутал /4-н улирал/	301
9	Өвлийн ажлын гутал	2
10	Усны гутал /зун/	48
11	Усны гутал /өвөл/	0
12	Эсгий оймс /усны гутлын/	58

Хүснэгт 14. Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олголт

№	Нэр төрөл	Тоо ширхэг
1	Каск /зун/	233
2	Каск /өвөл/	8
3	Нинжа малгай	0
4	Уутан малгай /нэг удаагийн/	70
5	3м маск /1 шүүлтүүртэй /	16
6	3м маск /2 шүүлтүүртэй /	12
7	3м шүүгч цаас	1490
8	Нэг удаагын маск 2.5 PM	13244
9	Ажлын цагаан бээлий	6765
10	Ажлын бээлий /резинэн алгатай/	24487
11	Бээлий /өвөл/	12
12	Бээлий / үйлдвэрийн/	1292
13	Лабораторийн бээлий	0
14	Нүдний шил	550
15	Ханцуйвч	14
16	Чихэвч	0
17	Чихний бөглөө	1102
18	Борооны цув	13

Хүснэгт 15. Ажлын тусгай хувцас олголт

№	Нэр төрөл	Тоо ширхэг
1	Гагнуурчны хувцас /хормогчтой/	0
2	Комбинзон /химийн бодис, тос тосолгоо/	0
3	Гагнуурчны малгай	0
4	Гагнуурчны баг	0
5	Тасдагчны нүүрэвч	0
6	Нүүрэвчтэй маск	0
7	Бээлий /гагнуурчны/	208
8	Өндрийн хамгаалалтын бүс	0
9	Шохойн комбинзон	0

### 7.3.3. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

7.3.3.1. Химийн бодисын агуулах, химийн бодис ашигладаг хэлтэс цехүүдийн ажлын байранд химийн бодис тус бүрийн ХАЛМ-ийг байрлуулсан байдаг ба шаардлагатай тохиолдолд шинэчлэн өдөр тутмын үйл ажиллагаанд ашигладаг. Мөн химийн

бодисын ХАЛМ-ийг гарын авлага хэлбэрээр бэлтгэж химийн бодистой харьцаж ажилладаг ажилтнуудад сургалт зохион байгуулах үедээ мэдээлэл хүргэсэн.



Зураг 40. ХАЛМ байрлуулсан байдал

7.3.3.2. Химийн бодистой харьцаж ажилладаг ажилтнуудад химийн бодистой аюулгүй харьцах мэдлэг, дадал, чававхыг нэмэгдүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулдаг. Баяжуулах үйлдвэрийн химийн бодис ашигладаг хэлтэс цехүүдийн ажилтнууд болон туслан гүйцэтгэгч аж ахуй нэгж байгуулла “Сор Сервис” ХХК-ийн ачигч нарт химийн бодис тус бүрийн ХАЛМ, химийн бодистой харьцах аюулгүй ажиллагааны зааварчилгаа, асгаралтын иж бүрдэл хэрэглэх, анхны тумламж, химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж, аюул ослын үед авах арга хэмжээ болон аюултай хог хаягдлын талаарх сэдвүүдийн хүрээнд химийн инженерүүд 11 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад нийт 155 ажилтан хамрагдаж, мэдлэг шалгах шалгалт авч, дүгнэдэг.





Зураг 41. Химийн бодисын тухай сургалт

7.3.3.3. Баяжуулах үйлдвэр, чанарын хэлтсийн лабораторид ашигладаг химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэлийг бодис нэг бүрээр гаргаж, агуулахын үлдэгдэл нөөц, ашиглалтын зарцуулалтыг дараах хүснэгтэд харуулсан байна.

Хүснэгт 16. Баяжуулах үйлдвэрийн химийн бодисын ашиглалт

№	Бодисын нэр, томьёо	Уялдуулсан системийн код	Хаана хадгалдаг	Эхний үлдэгдэл, кг, 2024 оны 12 сарын 26	Хүлээн авсан нийт хэмжээ, кг	Нийт хэрэглэсэн хэмжээ, кг	2025 оны 09 сарын 25 үлдэгдэл, кг
1	2	3	4	5	6	7	8
1	Цайрын сульфат $ZnSO_4$	7446-20-0	Химийн бодисын тусгай агуулах	56,000.00	616,000.00	627,000.00	45,000.00
2	Зэсийн сульфат $CuSO_4$	7758-98-7		26,000.00	208,300.00	186,300.00	48,000.00
3	Натрийн бутилксантат $C_4H_9OCSSNa$	141-33-3		12,750.00	60,050.00	60,800.00	12,000.00
4	Кониферолын тос $C_{10}H_{17}OH$	8002-09-3		7,400.00	1,200.00	6,800.00	1,800.00
5	Дикрезил-дителиофосфорын хүчил $(C_7H_7O)_2PSSH$	4384-82-1		74,200.00	-	7,000.00	67,200.00
6	Кальцийн оксид $CaO$	1305-78-8	Шохойн агуулах	662,187.00	3,162,200.00	3,526,002.40	298,384.60
7	Натрийн диэтилдителиокарбамат $(C_2H_5)_2NCSSNa \cdot 3H_2O$	20624-25-3	Химийн бодисын тусгай агуулах	43,250.00	-	2,000.00	41,250.00
8	Натрийн этилксантат $C_2H_5OCSSNa$	246-805-2		-	-	-	-
9	Натрийн сульфит $Na_2SO_3$	7757-83-7		-	-	-	-
10	Давсны хүчил $HCl$	7647-01-0		3,174.00	9,049.00	5,530.00	6,693.00
11	Азотын хүчил $HNO_3$	7697-37-2		1,620.00	15,050.00	14,045.00	2,625.00

Хүснэгт 17. Лабораторийн химийн бодисын ашиглалт

№	Бодисын нэр, томъёо	Уялдуулсан системийн код	Хаана хадгалдаг	Эхний үлдэгдэл, кг, 2024 оны 12 сарын 26	Хүлээн авсан нийт хэмжээ, кг	Хэрэглэсэн нийт хэмжээ, кг	2025 оны 10 сарын 25 үлдэгдэл, кг
1	Трилон Б C10H14N2O8Na2.2H2O	6381-92-6	Лабораторийн агуулах	8	0	3	5
2	Ксиленол шар C31H28N2Na4O13S	3618-43-7	Лабораторийн агуулах	0.085	0	0.015	0.07
3	Натрийн ацетат CH3COONa	127-09-3	Лабораторийн агуулах	303	100	157.5	245.5
4	Цууны хүчил CH3COOH	64-19-7	Лабораторийн агуулах	24	0	8	16
5	Аммонийн хлорид NH4Cl	12125-02-9	Лабораторийн агуулах	43.5	100	102	41.5
6	Аммонийн персульфа (NH4)2S2O8	7727-54-0	Лабораторийн агуулах	18	30	27.5	20.5
7	Натрийн тиосульфат Na2S2O3.5H2O	10102-17-7	Лабораторийн агуулах	17	40	32.5	24.5
8	Аскорбины хүчил C6H8O6	89924-69-6	Лабораторийн агуулах	22	40	36	26
9	Тиомочевин CH4N2S	62-56-6	Лабораторийн агуулах	22.5	0	3.25	19.25
10	Давсны хүчил HCl	7647-01-0	Лабораторийн агуулах	18	523	353.5	187.5
11	Хүхрийн хүчил H2SO5	7664-93-9	Лабораторийн агуулах	123.5	0	22	101.5
12	Азотын хүчил	7697-37-2	Лабораторийн агуулах	79	280	225	134
13	Аммикийн усан уусмал	1336-21-6	Лабораторийн агуулах	100	200	224	76
14	Калийн радонид	333-20-0	Лабораторийн агуулах	15.5	0	0.5	15
15	Натрийн тетраборат	1303-96-4	Лабораторийн агуулах	0.5	0	0.5	0
16	Аммонийн фторид	12125-01-8	Лабораторийн агуулах	12.75	0	4.25	8.5

7.3.3.4.“ОШМИ” группын ажлын байран дээрх эрсдлийн үнэлгээ ба эрсдлийн менежментийн сургалтад химийн инженерүүд болон хөдөлмөр хамгааллын инженерүүд 11-р сарын 27, 28-ны өдрүүдэд хамрагдана.

7.3.3.5.2025 онд 23 удаа химийн бодисын татан авалт хийсэн ба химийн бодисыг битүүмжлэлтэй тээврийн хэрэгслээр аюулгүй байдлыг ханган, тээвэрлэж байна.

Химийн бодисын агуулахад химийн бодис татан авалтын үед Дашбалбар сумын байгаль хамгаалагч болон хөдөлмөр хамгааллын инженерүүд аюул, ослоос урьдчилан сэргийлэхээр хяналт тавьж ажилладаг. Хэлтэс цехүүдийн өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах химийн бодис авалтын үед хөдөлмөр хамгааллын инженерүүд тухай бүр нь хяналт тавьж ажилладаг.



Зураг 42. Химийн бодис ачилт, буулгалтын өмнөх хяналт



Зураг 43. Химийн бодис тээвэрлэлтийн машин

7.3.3.6. Баяжуулах үйлдвэр болон химийн бодис ашигладаг, аюултай хог хаягдал үүсгэдэг 12 цэгт асгаралтын иж бүрдэл болон ашиглах заавар бүхий самбарыг байрлуулсан байдаг. Мөн химийн инженерүүд нь асгаралтын иж бүрдлийг хэрхэн ашиглах талаарх сургалтыг зохион байгуулсан. Асгаралтын иж бүрдлийг ашигласан тохиолдолд шингээх, арчих материалыг нөхөж хийхээр нөөцийг бүрдүүлсэн байдаг.



Зураг 44. Асгаралтын иж бүрдэл

## 8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 8.1. АХУЙН ХОГ ХАЯГДЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

8.1.1. Дахин боловсруулагдах хог хаягдлын ангилан ялгалтыг сайжруулахаар баяжуулах үйлдвэрийн цехүүдэд хуванцар хаягдлын хогийн сав, хуванцар хаягдлыг хэрхэн зөв ангилан ялгах талаар санамж байрлуулсан.



Зураг 45. Хуванцар хаягдлын хогийн сав

8.1.2. Хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, тээвэрлэх үйл ажиллагааг орон нутгийн “Дашбалбар хөгжил” ОНӨААТҮГ-тай “Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх” ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. “Дашбалбар хөгжил” ОНӨААТҮГ гэрээний дагуу уурхайн бүсэд ирж ажиллан, дахин боловсруулагдах хуванцар хаягдлыг хүлээн авдаг. Тайлант хугацаанд 440 кг хуванцар хаягдал тушаасан байна.



Зураг 46. Хогийн цэгийн цэвэрлэгээ

8.1.3. Уурхайн бүсэд үүссэн хог хаягдлыг цэвэрлэх, байгаль орчин болон хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллөөс урьчдиглан сэргийлэх зорилгоор 04, 06 болон 07-р саруудад бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулсан. “Шинь Шинь” ХХК-ийн хэлтэс цехүүд, туслан гүйцэтгэгч аж ахуй нэгжүүд өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй хэсэгт цэвэрлэгээг хийж гүйцэтгэдэг.



Зураг 47. Бүх нийтийн цэвэрлэгээ

8.1.4. Эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулаагүй болно.

## 8.2. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

8.2.1. Уурхайн бүсэд эрүүд мэндийн анхны тусламж үйлчилгээг үзүүлэхээр Дорнод аймгийн БОЭТ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажилладаг. Эмнэлэгийн гаралтай хог хаягдлыг уурхайн бүсэд томилолтоор ирж ажилласан эмч нар хариуцан, Дорнод аймгийн БОЭТ-д хүргүүлж, устгуулдаг.

Төслийн үйл ажиллагаанаас үүсч буй аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй, гэрээт байгууллагад шилжүүлэх хүртэл ангилал тус бүрээр бүртгэл хөтлөн, түр хадгалах цэгт хадгалдаг. Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй гэрээт байгууллагад 12760 литр ашигласан тос масло, 15060 кг химийн бодисын шуудай, 798 кг хуванцар канистр, 200 литрийн хэмжээтэй хуванцар 288 кг тушаасан байна.

Химийн бодисын шуудай 15223.5 кг, хуванцар сав 2093.8 кг, 8300 литр ашигласан тос масло зэрэг аюултай хог хаягдлыг ангилал тус бүрээр нь бүртгэл хөтлөн, түр хадгалах цэгт хадгалж байна.

### 8.3. БҮХ АНГИЛАЛД

8.3.1. 2025 оны Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу “Есүй Бэхи” ХХК-д 04, 10-р саруудад дотоод хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Байгаль орчны инженерүүд нь хог хаягдлын ангилан ялгалт, тээвэрлэлт, бүртгэл хөтлөлт зэрэгт хяналт хийж, дутагдал илэрсэн тохиолдолд албан бичгээр хүргүүлдэг.



Зураг 48. Дотоод хяналт шалгалт

8.3.2. 02-р сард “Хог хаягдлын ангилан ялгалт, хог хаягдлыг бууруулах менежмент” сэдвээр байгаль орчны инженерүүд сургалт зохион байгуулсан. Сургалтад 4 ээлжийн нийт 302 ажилтнууд мөн туслан гүйцэтгэгч компанийн 46 ажилтан хамрагдсан.



Зураг 49. Хог хаягдлын талаарх сургалт

## 9. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж буй өөрчлөлтийг хянах зорилгоор агаар, хөрс, ус, ургамал амьтан зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт судалгаа хийж, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнд дүгнэлт хийдэг.

Төлөвлөгөөт хавар, намрын ус, хөрс, агаарын дээжлэлт, улиралд 2-оос доошгүй удаа хаягдал усны дээжлэлтийг хийж хөндлөнгийн байгууллагатай хамтран орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### 9.1. АГААРЫН БОХИРДЛЫГ ХЯНАХ

Дорнод аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвтэй хамтран ажиллах гэрээний дагуу мэргэжилтнүүд уурхайн бүсэд ирж гадаад болон дотоод нийт 16 орчинд агаарын сорьцны дээжлэлт хийсэн. Агаарын даралт гПа, агаарын температур, нийт тоосонцор, азотын давхар исэл, хүхэрлэг хий, угаарын хийн шинжилгээний үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 18. Агаарын найрлагын шинжилгээний үр дүн

№	Агаарын сорьц авсан цэгийн байршил	Агаарын даралт		Агаарын температур		Хүхэрлэг хий		Нийт тоосонцор		Азотын давхар исэл	
		гПа		с		мкг/м <sup>3</sup>		мкг/м <sup>3</sup>		мкг/м <sup>3</sup>	
		5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар
1	Хаягдал сан баруун урагш	917.6	921.9	17	21.9	6	2	114	40	13	43
2	Хаягдлын сан	917.3	921.7	16.9	23.1	6	2	105	20	8	28
3	Буцах усан сан	918.3	921.4	15.7	23.5	8	2	147	69	10	33
4	Малчин айлын гадаа	918.6	920.9	15.1	25	8	3	98	68	8	22
5	Хүдрийн овоолго тэсрэх бодис	922.8	920.6	14.1	26.7	4	14	97	110	14	99
6	Далд уурхайн ам	922.8	920.4	14.1	27.2	11	5	1920	160	73	35
7	Дотоод тээврийн зам	919.1	920.2	11.8	25.3	7	5	115	121	19	20
8	Уурын зуухны гадна	922.9	919.6	12.5	23.9	4	8	111	70	10	18
9	Хүдрийн овоолго	919.4	919.7	11.1	21.7	6	4	273	130	21	26
10	Ажилтнуудын байрны гадна	916.1	919.7	17	20.8	10	6	117	50	40	32
11	Дүүргэлт	916.5	918	17.1	14.4	6	7	481	75	40	45
12	Хөвүүлэх машин	923.3	918.1	9.7	14.5	5	2	385	96	39	47
13	Хатаах цех	923.1	917.9	10.6	14.7	5	4	86	50	22	53
14	Уурын зуухны дотор	922.99	917.8	11.8	14.1	11	7	117	77	10	60
15	Бутлах дотор	916.3	917.4	17.4	14	20	7	2060	1440	32	53
16	Гадаад тээврийн зам эдэлбэрт өртөөгүй талбай	922.6	917.2	15	14.5	4	2	64	30	10	21
<b>Стандарт(MNS 4585:2016)</b>						<b>450</b>		<b>500</b>		<b>200</b>	

Төлөвлөгөөт хавар, намрын дээжлэлтийн шинжилгээний үр дүнг “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016” стандарттай харьцуулж, дүгнэлт хийдэг. Үр

дүнгээс бутлах цех, далд уурхайн амны хэсэгт нийт тоосонцор хүлцэх агууламжаас хэтэрсэн бол агаарын сорьц авсан бусад цэгүүдэд хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосонцорын агуулга агаарын чанарын стандартад нийцэж, хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

## 9.2.УСНЫ БОХИРДЛЫГ ХЯНАХ

Улаан, Мухарын холимог металлын орд төслийн талбайд ажиллаж, амьдарч байгаа ажилтныг эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл боломжоор хангах үүднээс усны эх үүсвэрүүдийн эрүүл ахуйд хяналтыг тогтмол тавин ажиллаж байна. Энэхүү хяналтын хүрээнд 2025 онд төслийн усан сангууд, гүн өрмийн худаг, унд ахуйн цэгүүдээс дээж авч, Ус цаг уур орчны шинжилгээний төв лаборатори, SGS IMME Mongolia LLC-ийн лаборатори, МУИС-Цөмийн судалгааны төвийн лаборатори, Усны газрын лаборатори, Дорнод аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лабораториудад хими судлал, цацраг идэвхт элемент, нян судлал, хими судлал, цацраг идэвхт элемент, хүнд металлын агуулгын шинжилгээг тогтмол хийлгэж байна. 10-р сарын байдлаар нийт 177 унд ахуй, ахуйн бохир, үйлдвэрлэл, хяналтын цооног, ойр орчмын булаг, малчин айлын гар худаг зэрэг цэгүүдээс дээж авч шинжлүүлсэн байна.

Усны дээжлэлт хийхдээ хөндлөнгийн хяналтаар Дашбалбар сумын байгаль хамгаалагч мөн “Итгэлт Төгөл” ХХК-ийн мэргэжилтэн нарыг байлцуулан аргачлалын дагуу усны дээжийг авч 48 цагийн дотор Улаанбаатар хот болон Дорнод аймаг дахь итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэхээр илгээж байна.


2025 оны орчны хяналт-шинжилгээний ажлын хүрээнд авсан усны дээжийг “Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS6148:2010”, “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал, Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018”, “Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус, Ерөнхий шаардлага MNS4943:2015” тус тус стандартуудтай харьцуулан дүгнэлт хийв.

### Үйлдвэрлэлийн усны дүн шинжилгээ


2025 оны төлөвлөгөөт хавар, намрын усны дээжлэлтүүдийг хийж гүйцэтгэн, үйлдвэрлэлийн усны хүнд металлын агууламжийг “Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус, Ерөнхий шаардлага MNS4943:2015” стандарттай харьцуулсан. Хүснэгт 19-д үйлдвэрлэлийн усны хүнд металлын дээжлэлтийн цэгүүдийг, график 2-т үйлдвэрлэлийн усны хүнд металлын агууламжийг харуулсан байна

Хүснэгт 19. Үйлдвэрлэлийн усны дээж авсан цэгүүдийн байршил


№	Дээжний дугаар	Дээж авсан байршил
1	УС-ХМ1	Хаягдлын сан
2	УС-ХМ2	Далд уурхайн шавхалтын ус налуу ам 945-р түвшин
3	УС-ХМ3	Дүүргэлт цехийн ус




*График 2а. Үйлдвэрлэлийн усан дахь хартугалганы агуулга*




*График 2б. Үйлдвэрлэлийн усан дахь цайрын агуулга*




*График 2в. Үйлдвэрлэлийн усан дахь хүнцэлийн агуулга*



*График 2г. Үйлдвэрлэлийн усан дахь кадмийн агуулга*



*График 2д. Үйлдвэрлэлийн усан дахь манганы агуулга*



*График 2е. Үйлдвэрлэлийн усан дахь төмрийн агуулга*

Үйлдвэрийн усны дээжлэлтийн шинжилгээний үр дүнд шинжилгээ хийхэд Fe төмөр, Cd кадми, Zn цайр, Pb хар тугалганы найрлага “Усны чанар. Хаягдал ус, Ерөнхий шаардлага MNS4943:2015” стандарттай харьцуулахад хэвийн хэмжээнд байна. Намрын дээжлэлтэд хаягдлын сангийн ус буюу УС-ХМ1 хүнцэлийн агууламж стандарттай харьцуулахад 1.43 дахин их, далд уурхайн шавхалтын ус налуу ам 945-р түвшин буюу УС-ХМ2 хүнцэлийн агууламж стандарттай харьцуулахад 1.23 дахин их, манганы агууламж стандарттай харьцуулахад 2.744 дахин их. Хаврын дээжлэлтээр далд уурхайн шавхалтын ус налуу ам 945-р түвшин УС-ХМ2-д хүнцэлийн агууламж 1.7 дахин их байна.

## Унд ахуйн усны дүн шинжилгээ

Унд ахуйн зориулалтаар ашиглаж буй гүн өрмийн худаг болон цэвэр усан сан, гал тогооны крантны ус, цэвэршүүлсэн ус мөн төслийн талбайд хамгийн ойр орших булаг зэрэг цэгүүдээс дээж авч ерөнхий хими, нян судлалын үзүүлэлтийг Дорнод аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилын лабораторид, хүнд металлын агууламжийг SGS IMME Mongolia LLC-ийн лабораторид шинжлүүлдэг. Шинжилгээний үр дүнг “Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018” стандарттай харьцуулсан. Унд-ахуйн усны дээжлэлтийн цэгүүдийг доор хүснэгтэд харуулав.

Унд ахуйн усан дахь химийн үзүүлэлтийг доорх графикт харуулсан байна. Үр дүнгээс харахад ундны усан дахь хатуулаг, хлорид болон усны орчин нь бүх дээжийн цэгүүдэд хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 20. Ундны усны дээж авсан цэгүүдийн байршил

№	Дээж авсан байршил	Дээжний дугаар
1	Гүн өрмийн 1-р худаг	УС-1
2	Гүн өрмийн 3-р худаг	УС-2
3	Гүн өрмийн 4-р худаг	УС-3
4	Гүн өрмийн 5-р худаг	УС-4
5	Гүн өрмийн 6-р худаг	УС-5
6	Гүн өрмийн 7-р худаг	УС-6
7	Гүн өрмийн 8-р худаг	УС-7
8	Гүн өрмийн 9-р худаг	УС-8
9	Баруун сүүжийн булгийн ус	УС-9
10	Цэвэр усан сан	УС-10
11	Ундны ус. Цэвэршүүлсэн ус	УС-11
12	Ундны ус. Гал тогооны крантны ус	УС-12




График 3а. Ундны усан дахь хлорын агуулга




График 3б. Ундны усан дахь хатуулаг




График 3в. Ундны усны усны орчин

Ундны усны эх үүсвэрийн худгууд, усан сан, цэвэршүүлсэн ус, цэвэр усан сан зэргээс жилд хоёр удаагийн давтамжтай дээж авч, итгэмжлэгдсэн лабораторид илгээж шинжлүүлдэг. Ундны усны хүнд металлын агуулгийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 21. Ундны усан дахь хүнд металлын агуулга

Огноо	Хүнцэл As		Манган Mn		Төмөр Fe		Хар тугалга Pb		Цайр Zn		Кадми Cd		Уран U	
	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар	5-р сар	9-р сар
<b>MNS 0900:2018</b>	<b>0.01</b>			<b>0.1</b>	<b>0.3</b>		<b>0.01</b>		<b>5</b>		<b>0.03</b>		<b>0.03</b>	
Гүн өрмийн 1-р худаг	0.0018	0.00194	0.012	0.026	0.055	<0.05	<0.0005	<0.0005	<0.005	<0.005	0.00002	0.00002	0.0246	0.0224
Гүн өрмийн 2-р худаг		0.00442		0.008		<0.05		<0.0005		0.018		0.00014		0.0402
Гүн өрмийн 5-р худаг	0.00191		<0.005		0.054		<0.0005		<0.005		0.00002		0.0121	
Гүн өрмийн 6-р худаг	0.00437	0.00412	0.111	0.107	<0.05	<0.05	<0.0005	<0.0005	0.012	<0.005	0.00003	0.00002	0.0519	0.0415
Гүн өрмийн 7-р худаг	0.00107		<0.005		0.118		<0.0005		0.034		0.00003		0.0195	
Гүн өрмийн 8-р худаг	0.00059		0.178		0.088		<0.0005		<0.005		0.00003		0.0324	
Гүн өрмийн 9-р худаг	0.00192		<0.005		0.066		<0.0005		0.008		<0.00001		0.0154	
Баруун сүүжийн булгийн ус	0.00567	0.00597	0.012	<0.005	<0.05	<0.05	<0.0005	<0.0005	<0.005	0.012	0.00005	0.00017	0.00641	0.00797
Цэвэр усан сан	0.0007	0.00088	0.018	0.015	<0.05	0.052	<0.0005	<0.0005	<0.005	<0.005	0.00001	0.00004	0.0285	0.031
Ундны ус. Цэвэршүүлсэн ус	0.00003	0.00009	<0.005	<0.005	<0.05	<0.05	<0.0005	<0.0005	<0.0005	0.005	<0.00001	0.00003	0.000084	0.000297
Ундны ус. Гал тогооны крантны ус	0.00073	0.0008	0.007	<0.005	0.055	<0.05	<0.0005	<0.0005	0.006	0.012	0.00002	0.0002	0.0284	0.0287
Малчин Б.Мөнхбаг гүн өрмийн худаг	0.00334		<0.005		<0.05		<0.0005		0.005		<0.00001		0.0106	
Малчин Д.Дашбаяр гар худаг	0.00446		0.011		<0.05		<0.0005		0.005		<0.00001		0.0157	
Малчин Б.Батжаргал гар худаг	0.00418		<0.005		<0.05		<0.0005		0.013		<0.00001		0.0038	
Гоожуур гүний ус	0.0043		<0.005		<0.05		<0.0005		0.005		0.00001		0.0145	
Эрхэтийн уурхайн тогтмол ус	0.141		<0.005		<0.05		<0.0005		0.005		0.00006		1.54	
Малчин М.Миш-Иш гар худаг	0.00513		0.013		0.179		<0.0005		0.006		<0.00001		0.0495	

Уурхайн бүсийн ойр орчмын малчин өрхийн гар болон гүний худгаас жилд нэг удаа дээжлэлт хийж хүнд металл, химийн үзүүлэлтийг шинжлүүлдэг. Хүснэгт 22-г дээж авсан байршил, график 4-т үр дүнг “Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шардлага, чанар аюулгүй байдын үнэлгээ MNS0900:2018” стандарттай харьцуулан үзүүлэв.

Хүснэгт 22. Уурхайн бүсийн ойр орчмын ундны усны дээж авсан цэгүүдийн байршил

№	Дээж авсан байршил	Дээжний дугаар
1	Малчин Б.Мөнхбат гүн өрмийн худаг	УС-ДБО1
2	Малчин Д.Дашбаяр гар худаг	УС-ДБО2
3	Малчин Б.Батжаргал гар худаг	УС-ДБО3
4	Гоожуур гүний ус	УС-ДБО4
5	Эрхэтийн уурхайн тогтмол ус	УС-ДБО5
6	Малчин М.Миш-Иш гар худаг	УС-ДБО6




График 4а. Усан дахь хатуулаг






График 4б. Усны орчин



*График 4в. Усан дахь манганы агуулга*

Хаягдлын сангийн хяналтын цооногуудаас жилд 2 удаа дээжлэлт хийж, хүнд металл болон химийн үзүүлэлтийг шинжлүүлдэг. Хүнд металлын шинжилгээний үр дүнг “Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS6148:2010” стандарттай харьцуулан, доорх графикт харуулав.

Хяналтын цооног АЗ-т хар тугалганы агуулга стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс намрын дээжлэлтэд 1.052 дахин хэтэрсэн бол бусад цэгүүдэд стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй хэвийн байна.



*График 5а. Хяналтын цооногийн усан дахь хар тугалганы агуулга*



График 5б. Хяналтын цооногийн усан дахь цайрын агуулга




График 5в. Хяналтын цооногийн усан дахь хүнцэлийн агуулга




График 5г. Хяналтын цооногийн усан дахь ураны агуулга

### 9.3. ХӨРСНИЙ БОХИРДЛЫГ ХЯНАХ

Хөрсний хяналт-шинжилгээг хүснэгт 23-т заасан цэгүүдээс дээж авч, итгэмжлэгдсэн лабораториудад шинжлүүлсэн. Хүнд металлын дээжийг SGS IMME Mongolia LLC-Ийн лаборатори, цацраг идэвхт элемент дээжийг МУИС-Цөмийн судалгааны төв лаборатори, нефть бүтээгдэхүүний дээжийг Цаг уур орчны шинжилгээний газар Байгаль орчин хэмжил зүйн лаборатори, нян судлалын дээжийг Дорнод аймгийн Стандарт хэмжил зүйн лабораторид тус тус жилд хоёр удаа шинжлүүлдэг. 10-р сарын байдлаар нийт 278 дээжийг шинжлүүлээд байна. Хөрсний шинжилгээний үр дүнг “Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2019” стандарттай харьцуулан дүгнэлт хийсэн.

#### Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн

Хөрсний хүнд элементүүд нь хөрс үүсгэгч эх чулуулгаас уламжлагдан мөн агаараас аэрозоль байдлаар шингэж хуримтлагддаг. Хүнд элемент нь бусад бохирдуулагчтай харьцуулахад задрах, саармагжих, цэвэрших зэрэг процесст амархан ордоггүй бөгөөд хөрсөнд удаан хугацаагаар хуримтлагдаж, дан ганц хөрсийг бус хүрээлэн буй орчныг бүхэлд нь бохирдуулдаг. Хүнд элементүүдийн дотроос хүнцэл, мөнгөн ус, хар тугалга, кадми, хром, цайр зэрэг элементүүд нь нөлөөллийн хувьд хортойд тооцогдоно.

Хөрсний хүнд металлын агууламжийг тодорхойлох, хуримтлал үүсэж байгаа эсэхийг тодруулахаар талбай дахь хатуу цэгүүдээс хөрсний дээж аван SGS IMME Mongolia LLC-ийн лабораторид жилд 2 удаа шинжлүүлдэг. Хөрсөн дэх хүнд металлын агууламжийг график 6-д харууллаа.

Хүснэгт 23. Хөрсний хүнд металлын дээж авсан цэгүүдийн байршил

№	Дээжний дугаар	Дээж авсан байршил
1	ХӨРС-ХМ1	Буцах усан сан хойд тал
2	ХӨРС-ХМ2	ХӨРС-ХМ1 цэгээс хойш 250 метрт
3	ХӨРС-ХМ3	Хаягдлын сангийн баруун урд тал
4	ХӨРС-ХМ4	Баруун сүүжийн булгийн хажуугийн хөрс
5	ХӨРС-ХМ5	Ахуйн хог хаягдлын цэг
6	ХӨРС-ХМ6	Хуучин цэвэрлэх байгууламжийн орчим
7	ХӨРС-ХМ7	Далд уурхайн амнаас 250 метрт
8	ХӨРС-ХМ8	Бетон зуурмагийн цехээс урагш
9	ХӨРС-ХМ9	Эдэлбэрт өртөөгүй талбай хусан төгөл
10	ХӨРС-ХМ10	Хүдрийн овоолго химийн бодисын агуулах
11	ХӨРС-ХМ11	Далд уурхайн хажуу дахь хусан төгөл
12	ХӨРС-ХМ12	Баяжуулах үйлдвэр хатаах цех хажуугийн хөрс
13	ХӨРС-ХМ13	уурын зуухны баруун төлын хусан төгөл
14	ХӨРС-ХМ14	Авто граш
15	ХӨРС-ХМ15	Малчин М.Миш-Иш гар худгийн хажуугийн хөрс
16	ХӨРС-ХМ16	Дүүргэлт цехийн зүүн урт тал
17	ХӨРС-ХМ17	Дүүргэлт цехийн хойд тал 50 метрт
18	ХӨРС-ХМ18	Дүүргэлтийн цехийн химийн бодисын агуулахын зүүн тал
19	ХӨРС-ХМ19	Аймаг явах зам дагуу

20	ХӨРС-ХМ20	Хаягдлын сангийн баруун тал
21	ХӨРС-ХМ21	Хаягдлын сангийн ойд тал
22	ХӨРС-ХМ22	Хаягдлын сангийн зүүн тал




График ба. Хөрсөн дэх хүнцэлийн агуулга




График бб. Хөрсөн дэх хар тугалганы агуулга




График бв. Хөрсөн дэх цайрын агуулга




График бд. Хөрсөн дэх кадмийн агуулга




График бг. Хөрсөн дэх хромын агуулга




График 6е. Хөрсөн дэх зэсийн агуулга

### Хөрсний нефть бүтэгдэхүүн, агрохимийн шинжилгээний үр дүн

Төслийн талбайгаас хөрсний нефть бүтээгдэхүүний бохирдлыг тодорхойлох зорилгоор 4 цэгээс дээж авсан. Ус цаг уур, Орчны шинжилгээний газар Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид жилд хоёр удаа дээжлэлт хийж, шинжилгээнд өгдөг. Хүснэгт 25-д хөрсний агрохимийн шинжилгээний үр дүнг, хүснэгт 24-д хөрсний нефть бүтээгдэхүүний агууламжийг гр/кг-аар харуулав.

Хүснэгт 24. Хөрсний нефть бүтээгдэхүүний дээж авсан цэгийн байршил

№	Дээжний дугаар	Дээж авсан байршил	Дээжний үр дүн гр/кг
1	ХӨРС-НБ1	Далд уурхайн амны ШТС түр цэг	0.46
2	ХӨРС-НБ2	Далд уурхайн амны засварын газар	35.74
3	ХӨРС-НБ3	Түлш хадгалах түр цэг	0.2
4	ХӨРС-НБ4	Авто граш	0.04

ХӨРС-НБ2 дээжний үр дүн хөрсөн дэх газрын тосны бүтээгдэхүүний хортой агууламжаас 3.574 дахин хэтэрсэн бол бусад дээжний үр дүн хортой агууламжаас хэтрээгүй хэвийн байна.

Хүснэгт 25. Агрохимийн шинжилгээний үр дүн

№	Дээжний авсан байршил	Аммонийн азот /NH <sub>4</sub> /	Нитрат азот /NO <sub>3</sub> /	Сульфат /SO <sub>4</sub> /	Фосфор /P <sub>2</sub> O <sub>5</sub> /	Хөрсний орчин /рН/	ЦДЧ /ЕС/	Ялзмаг
1	Хүлэмжийн хөрс	34.5	4.2	5.8	4.3	8.67	0.04	3.3
2	Хүлэмж орчим элэгдэл ороогүй	28.7	5	3.6	2.9	8.09	0.02	3.9
3	Тарилт хийх талбай	245.4	130.9	15.3	24.5	8.43	0.58	3.7
4	Эдэлбэрт өртөөгүй талбай	16.2	31.8	16	7	6.47	0.1	6.1
5	Дорнод явах зам дагуу талбай	11	13.3	10.2	4.1	6.39	0.07	3.4
6	Мардайн тарилт хийх	6.63	20.9	10.2	40.1	7.05	0.04	2.1

## 9.4.ЦАЦРАГИЙН БОХИРДЛЫГ ХЯНАХ

“Шинь Шинь” ХХК-ийн Улаан, Мухарын холимог металлын ордын ураны хүдрийн биетийг цулын гэрээгээр хамгаалсан байдаг. Иймд тус компанийн цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрмийн дагуу хяналтын болон ажиглалтын бүсүүдэд агаар дахь радон болон ионжуулагч цацрагийн тунгийн чадлын хэмжилтийг тогтмол хийж гүйцэтгэж байна.

### Хяналт болон ажиглалтын бүсийн байршил

Хяналт болон ажиглалтын бүсийг тогтоохдоо агаар дахь радоны хуримтлал, ионжуулагч цацрагийн тунгийн чадлын хэмжилтийн дүнг үндэслэн хэмжилт хийх цэгийг тогтоосон.

Хүснэгт 26. Хяналтын болон ажиглалтын бүсийн байршил

№	Бүс	Хэмжилт хийх цэгийн байршил					
		Шалган 1	Шалган 2	Зочид буудал	Том оффис	Соёлын танхим	Хоолны газар хятад
1	Ажиглалтын бүс	Хоолны газар монгол	Ажилчдын байр-3	Ажилчдын байр-2	Ажилчдын байр-1	Эмнэлэг	Үйлдвэрийн оффис
		Хацарт бутлуур	Конусан бутлуур	Шигшүүр	Шохойн цех	Тээрэм	
		Флотаци машин	Хатаах цех	Хартугалганы баяжмал савлах машин	Цайрын баяжмал савлах машин	Хүдэр тээвэрлэх зам дагуу	
2	Хяналтын бүс	Далд уурхай налуу ам					

### Ажиглалтын бүс дэх агаар дахь радоны хуримтлал

Ажиглалтын бүс болох ажилчдын тосгон болон баяжуулах үйлдвэрт агаар дахь радоны хуримтлалын хэмжилтийг долоо хоног бүр хэмжилтийн цэг дээр тогтмол хийж гүйцэтгэж байна. Хэмжилтийн дүнг цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, цацрагийн аюулгүйн норм (MNS 5627:2006)-тай харьцуулахад хэвийн хэмжээнд байна. Ажилчдын тосгоны хэмжилтийн дундаж утга болон хамгийн их утгыг хүснэгт 27-д, баяжуулах үйлдвэрийн дундаж болон хамгийн их утгыг хүснэгт 28-д харуулав.

Хүснэгт 27. Ажиглалтын бүс дэх тосгоны агаар дахь радоны хуримтлалын хэмжилтийн дундаж утга

№	Байрлал	Он	Хэмжсэн тоо	Хэмжилтийн дундаж утга Бк/мЗ
1	Шалган 1	2025	24	80.5
2	Шалган 2	2025	24	63
3	Зочид буудал	2025	24	67.6
4	Том оффис	2025	24	50.7
5	Монгол хоолны газар	2025	26	85
6	Хоолны газар хятад	2025	24	51
7	Ажилчдын байр-1	2025	24	63.9
8	Ажилчдын байр-2	2025	24	58.2
9	Ажилчдын байр-3	2025	26	72.6
10	Эмнэлэг	2025	24	71.5

11	Үйлдвэрийн оффис	2025	24	70.7
----	------------------	------	----	------

*Хүснэгт 28. Ажиглалтын бүс дэх баяжуулах үйлдвэрийн агаар дахь радоны хуримтлалын хэмжилтийн дундаж утга*

№	Байрлал	Он	Хэмжсэн тоо	Хэмжилтийн дундаж утга Бк/м3
1	Хацарт бутлуур	2025	30	109.4
2	Конусан бутлуур	2025	30	86.7
3	Шигшүүр	2025	30	54.8
4	Шохой	2025	32	65.4
5	Тээрэм	2025	30	84.8
6	Флотацийн машин	2025	30	85.7
7	Хатаах шаазан машин	2025	30	96.8
8	Хар тугалга баяжмал савлах	2025	32	85.6
9	Цайр баяжмал савлах	2025	30	78.9

### **Ажиглалтын бүс дэх ионжуулагч цацрагийн тунгийн чадлын хэмжилтийн дүн**

Ажиглалтын бүс болох ажилчдын тосгон болон баяжуулах үйлдвэр, хүдэр тээвэрлэх зам дагуух ионжуулагч цацрагийн тунгийн чадлын хэмжилтийг долоо хоног бүр хэмжилтийн цэг дээр тогтмол хийж гүйцэтгэж байна. Хэмжилтийн дүнг цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, цацрагийн аюулгүйн норм (MNS 5631:2006)-тай харьцуулахад хэвийн хэмжээнд байна. Ажилчдын тосгоны хэмжилтийн дундаж утгыг хүснэгт 29-д , баяжуулах үйлдвэрийн дундаж утгыг хүснэгт 30-д, хүдэр тээвэрлэлтийн зам дагуух хэмжилтийн дундаж утгыг хүснэгт 31-д харуулав.

*Хүснэгт 29. Ажиглалтын бүс дэх кемпийн гамма цацрагийн тунгийн чадлын дундаж утга*

№	Байрлал	Он	Хэмжсэн тоо	Хэмжилтийн дундаж утга мкЗв/цаг	Хэмжилтийн дундаж алдаа (%)
1	Шалган 1	2025	42	0.10-0.16	20
2	Тоглоомын талбай	2025	42	0.10-0.16	20
3	Шалган 2	2025	42	0.10-0.16	20
4	Зочид буудал	2025	42	0.10-0.16	20
5	Зочид буудал гадаа	2025	42	0.10-0.16	20
6	Том оффис гадаа	2025	42	0.10-0.16	20
7	Том оффис дотор	2025	42	0.10-0.16	20
8	Явган хүний зам	2025	42	0.10-0.16	20
9	Хятад гал тогоо	2025	42	0.10-0.16	20
10	Монгол гал тогоо	2025	42	0.10-0.16	20
11	Ажилчдын байр-1	2025	42	0.10-0.16	20
12	Ажилчдын байр-2	2025	42	0.10-0.16	20
13	Ажилчдын байр-3	2025	42	0.10-0.16	20
14	Эмнэлэг	2025	42	0.10-0.16	20
15	Үйлдвэрийн оффис	2025	42	0.10-0.16	20

*Хүснэгт 30. Ажиглалтын бүс дэх баяжуулах үйлдвэрийн гамма цацрагийн тунгийн чадлын дундаж утга*

№	Байрлал	Он	Хэмжсэн тоо	Хэмжилтийн дундаж утга мкЗв/цаг	Хэмжилтийн дундаж алдаа (%)
1	Хацар бутлуур сэткен	2025	42	0.15-0.20	20
2	Хүдрийн овоолго	2025	42	0.15-0.20	20
3	Хацар бутлуур дотор	2025	42	0.09-0.13	20
4	Конусан бутлуур дотор	2025	42	0.11-0.15	20
5	Шигшүүр дотор	2025	42	0.11-0.16	20
6	Шохой	2025	42	0.09-0.12	20
7	Тээрэм	2025	42	0.06-0.10	20
8	Флотацийн машин	2025	42	0.05-0.10	20
9	Хатаах шаазан машин	2025	42	0.10-0.12	20
10	Хар тугалга баяжмал савлах хэсэг	2025	42	0.11-0.15	20
11	Цайр баяжмал савлах хэсэг	2025	42	0.11-0.15	20
12	Уурын зуухны цех	2025	42	0.12-0.16	20

*Хүснэгт 31. Ажиглалтын бүс дэх хүдэр тээвэрлэх зам дагуух гамма цацрагийн тунгийн чадлын хэмжилтийн дундаж утга*

№	Байрлал	Он	Хэмжсэн тоо	Хэмжилтийн дундаж утга мкЗв/цаг	Хэмжилтийн дундаж алдаа (%)
1	Хүдэр тээвэрлэлтийн зам дагуу N 49°04'56,34" E114°05'54,90"	2025	42	0.14-0.18	20
2	Хүдэр тээвэрлэлтийн зам дагуу N 49°04'59,64" E114°05'53,39"	2025	42	0.14-0.18	20
3	Хүдэр тээвэрлэлтийн зам дагуу N 49°04'59,64" E114°05'56,50"	2025	42	0.13-0.18	20
4	Хүдэр тээвэрлэлтийн зам дагуу N 49°04'58,26" E114°05'40,15"	2025	42	0.14-0.16	20
5	Хүдэр тээвэрлэлтийн зам дагуу N 49°04'57,03" E114°05'34,99"	2025	42	0.14-0.18	20
6	Хүдэр тээвэрлэлтийн зам дагуу N 49°04'57,30" E114°05'30,15"	2025	42	0.14-0.18	20
7	Хүдэр тээвэрлэлтийн зам дагуу N 49°04'58,89" E114°05'25,14"	2025	42	0.14-0.18	20
8	Хүдэр тээвэрлэлтийн зам дагуу N 49°05'00,45" E114°05'20,46"	2025	42	0.14-0.18	20
9	Хүдэр тээвэрлэлтийн зам дагуу N 49°05'01,68" E114°05'14,82"	2025	42	0.14-0.18	20
10	Хүдэр тээвэрлэлтийн зам дагуу N 49°05'02,52" E114°05'10,25"	2025	42	0.13-0.19	20

**Хяналтын бүс дэх агаар дахь радоны хуримтлалын дүн**

Хяналтын бүс болох налуу амны түвшинүүдэд агаар дахь радоны хуримтлалын хэмжилтийг өдөр бүр хийж гүйцэтгэж байна. Хэмжилтийн дүнг цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, цацрагийн аюулгүйн норм, (MNS 5627:2006)-тай харьцуулахад хэвийн хэмжээнд байна. Хэмжилтийн дундаж утгыг хүснэгт 32-т харуулав.

*Хүснэгт 32. Хяналтын бүс дэх налуу амны агаар дахь радоны хуримтлалын хэмжилтийн дундаж утга*

№	Байрлал	Он	Хэмжсэн тоо	Хэмжилтийн дундаж утга Бк/м3
1	945 түвшин	2025	44	107.9
2	885 түвшин	2025	30	190.5
3	930 түвшин	2025	36	150.6
4	981 түвшин	2025	42	73.8
5	825 түвшин	2025	30	229.1
6	765 түвшин	2025	28	208.9

**Хяналтын бүс дэх ионжуулагч цацрагийн тунгийн чадлын хэмжилтийн дүн**

Хяналтын бүс болох налуу амны түвшинүүдэд ионжуулагч цацрагийн тунгийн чадлын хэмжилтийг өдөр бүр хийж гүйцэтгэж байна. Хэмжилтийн дүнг цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, цацрагийн аюулгүйн норм (MNS 5631:2006)-тай харьцуулахад хэвийн хэмжээнд байна. Хэмжилтийн дундаж утгыг хүснэгт 33-т харуулав.

*Хүснэгт 33. Хяналтын бүс дэх налуу амны гамма цацрагийн тунгийн чадлын хэмжилтийн дундаж утга*

№	Байрлал	Он	Хэмжсэн тоо	Хэмжилтийн дундаж утга мкЗв/цаг	Хэмжилтийн дундаж алдаа (%)
1	945 түвшин	2025	44	0.15-0.35	10
2	885 түвшин	2025	30	0.20-0.40	10
3	930 түвшин	2025	36	0.17-0.40	10
4	981 түвшин	2025	42	0.14-0.28	10
5	825 түвшин	2025	30	0.20-0.40	10
6	765 түвшин	2025	28	0.18-0.45	10

**Хяналтын бүс дэх гадаргуугийн бохирдолтын хэмжилтийн дүн**

Гадаргуугийн бохирдлыг тодорхой заасан цэгүүдэд хэмжилтийг хийж гүйцэтгэж байна. Хэмжилтийн дүнг цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, цацрагийн аюулгүйн норм (MNS 5630:2006)-тай харьцуулахад хэвийн хэмжээнд байна. Хэмжилтийн дундаж утга болон хамгийн их утгыг хүснэгт 34-т харуулав.

*Хүснэгт 34. Хяналтын бүс дэх бохирдолтын хэмжилтийн дүн*

№	Байрлал	Он	Хэмжсэн тоо	Хэмжилтийн хамгийн бага утга Срm	Хэмжилтийн хамгийн их утга Срm
1	Хоолны өрөө ширээ, сандал	2025	40	50	100
2	Хурлын өрөө ширээ, сандал	2025	38	50	100
3	Ачааны машин сандал	2025	36	50	100
4	Хувцас солих өрөө, шүүгээ	2025	48	50	100
5	Ковшийн сандал	2025	46	50	100

**Гадаад орчны болон хүн амын цацрагийн хяналт**

Хүн амын цацрагийн хяналтын хэмжилтийг уурхайн орчмын малчин өрхүүдийн орчны ионжуулагч цацрагийн тунгийн чадлын хэмжилтийг хийж гүйцэтгэж байна. Хэмжилтийн дүнг цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм, цацрагийн аюулгүйн норм (MNS 5631:2006)-тай харьцуулахад хэвийн хэмжээнд байна. Хэмжилтийн дундаж утга болон хамгийн их утгыг хүснэгт 35-д харуулав.

№	Өрхийн тэргүүн	Цацрагийн тунгийн чадал (мкЗв/цаг)	Он сар өдөр	Уурхайн талбайгаас
1	М.Миш-Иш	0.08-0.12	2025.01.24	15-16 км
2	Х.Хүрэлчулуун	0.10-0.12	2025.01.24	3-4 км
3	Л.Отгонбаатар	0.11-0.12	2025.01.24	6-7км
4	М.Миш-Иш	0.09-0.13	2025.02.22	15-16 км
5	Х.Хүрэлчулуун	0.08-0.13	2025.02.22	3-4 км
6	Л.Отгонбаатар	0.10-0.13	2025.02.22	6-7км
7	Х.Хүрэлчулуун	0.10-0.13	2025.03.22	3-4 км
8	Л.Отгонбаатар	0.11-0.12	2025.03.22	6-7км
9	М.Миш-Иш	0.08-0.12	2025.03.22	15-16 км
10	Х.Хүрэлчулуун	0.11-0.13	2025.04.18	3-4 км
11	Л.Отгонбаатар	0.11-0.13	2025.04.18	6-7км
12	М.Миш-Иш	0.06-0.08	2025.04.18	15-16 км
13	Х.Хүрэлчулуун	0.10-0.13	2025.05.17	3-4 км
14	Л.Отгонбаатар	0.10-0.12	2025.05.17	6-7км
15	М.Миш-Иш	0.08-0.10	2025.05.17	15-16 км
16	Х.Хүрэлчулуун	0.09-0.11	2025.06.13	3-4 км
17	Л.Отгонбаатар	0.09-0.12	2025.06.13	6-7км
18	М.Миш-Иш	0.06-0.09	2025.06.13	15-16 км
19	Х.Хүрэлчулуун	0.08-0.12	2025.07.29	3-4 км
20	Л.Отгонбаатар	0.09-0.12	2025.07.29	6-7км
21	М.Миш-Иш	0.08-0.10	2025.07.29	15-16 км
22	Х.Хүрэлчулуун	0.07-0.12	2025.08.29	3-4 км
23	Л.Отгонбаатар	0.10-0.13	2025.08.29	6-7км
24	М.Миш-Иш	0.11-0.12	2025.08.29	15-16 км
25	Х.Хүрэлчулуун	0.08-0.11	2025.09.24	3-4 км
26	Л.Отгонбаатар	0.09-0.13	2025.09.24	6-7км
27	М.Миш-Иш	0.09-0.12	2025.09.24	15-16 км
28	Х.Хүрэлчулуун	0.6-0.10	2025.10.24	3-4 км
29	Л.Отгонбаатар	0.08-0.11	2025.10.24	6-7км
30	М.Миш-Иш	0.08-0.12	2025.10.24	15-16 км

### Хүрээлэн буй орчны цацрагийн хяналт

Хүрээлэн буй орчны цацрагийн хяналтын хүрээнд МУИС-н дэргэдэх Цөмийн физикийн судалгааны төвийн итгэмжлэгдсэн лабораториар уурхайн усан дахь изотопуудын хувийн идэвхийг жилд хоёр удаа тодорхойлуулсан. Шинжилгээний хариуны дүнг (MNS0900:2018)-тай харьцуулахад изотопуудын хувийн идэвх ундны усанд зөвшөөрөгдөх хэмжээнд байна. Малчин өрхийн ундны уснаас авсан дээжний шинжилгээний дүнгээс харахад изотопуудын хувийн идэвх зөвшөөрөгдөх хэмжээнд байна.

Хүснэгт 36. Усанд изотопуудын хувийн идэвх тодорхойлсон лабораторийн шинжилгээний хариу

№	Дээжийн нэр	Изотопуудын хувийн идэвх, Бк/л				
		<sup>214</sup> Pb	<sup>214</sup> Bi	<sup>222</sup> Rn	<sup>226</sup> Ra	<sup>238</sup> U
1	Хаягдлын сангийн ус	13	18.5	15.5	<0.6	<0.6
2	Хаягдлын сан. Хяналтын цооног ЭЖ-2	217	253	236.5	<0.6	<0.6
3	Хаягдлын сан. Хяналтын цооног А-3	11.5	17	14.5	<0.6	<0.6
4	Хаягдлын сан. Хяналтын цооног ЭЖ-3	95.5	119	107.5	<0.6	<0.6
5	Хаягдлын сан. Хяналтын цооног А-2	88.5	103	95.5	<0.6	<0.6
6	Хуучин цэвэрлэх байгууламж орчим	43.5	49.5	46.5	<0.6	<0.6
7	Буцах усан сангийн хажуу дахь хурамтлалын худаг	145	170.5	157.5	<0.6	<0.6
8	Хаягдлын сан. Хяналтын цооног ЭЖ-4	70	80	75	<0.6	<0.6
9	Далд уурхайн шавхалтын ус налуу ам 945-р түвшин	7.5	10.5	9	<0.6	<0.6
10	Баруун сүүжийн булгийн ус	46	62	54	<0.6	<0.6
11	Ундны ус. Гүн өрмийн 1-р худаг	17.5	20	19	<0.6	<0.6
12	Ундны ус. Гүн өрмийн 2-р худаг	24	31	28	<0.6	<0.6
13	Ундны ус. Гүн өрмийн 5-р худаг	66	85	76	<0.6	<0.6
14	Ундны ус. Гүн өрмийн 6-р худаг	16	16.5	16	<0.6	<0.6
15	Ундны ус. Гүн өрмийн 7-р худаг	51	61	56	<0.6	<0.6
16	Ундны ус. Гүн өрмийн 8-р худаг	5	1.5	2	<0.6	<0.6
17	Ундны ус. Гүн өрмийн 9-р худаг	10	11	11	<0.6	<0.6
18	Ахуйн бохир усны гаралт	13.5	24.5	19.5	<0.6	<0.6
19	Ундны ус. Монгол гал тогооны крантны ус.	12	17.5	14.5	<0.6	<0.6
20	Ундны ус. Цэвэршүүлсэн ус	5	7	6	<0.6	<0.6
21	Цэвэр усан сан	10.5	6	7.5	<0.6	<0.6
22	Жалганд тогтсон ус	17	15	16	<0.6	<0.6
23	Дүүргэлт цехийн ус	1.5	5	3.5	<0.6	<0.6
<b>Илрүүлэх доод хязгаар (1л эзэлхүүнтэй, 1цаг хэмжих үед)</b>		1.3	1.5	1.4	<0.6	<0.6
<b>Ундны усны зөвшөөрөгдөх хэмжээ MNS0900:2018</b>		-	-	100	-	-

Хүснэгт 37. Малчин өрхийн ундны усанд изотопуудын хувийн идэвхийг тодорхойлсон лабораторийн шинжилгээний хариу

№	Дээжийн нэр	Изотопуудын хувийн идэвх, Бк/л				
		<sup>214</sup> Pb	<sup>214</sup> Bi	<sup>222</sup> Rn	<sup>226</sup> Ra	<sup>238</sup> U
1	Малчин Б.Мөнхбат гүн өрмийн худаг	21	32	26	<0.6	<0.6
2	Малчин Д.Дашбаяр гар худаг	5	4	4	<0.6	<0.6
3	Малчин Б.Батжаргал гар худаг	17	20	18	<0.6	<0.6
4	Малчин М.Миш-Иш гар худаг	20	23	21	<0.6	<0.6
5	Гоожуур гүний ус	25	27	26	<0.6	<0.6
6	Эрхэтийн уурхайн тогтмол ус	2	4	3	<0.6	<0.6
<b>Илрүүлэх доод хязгаар (1л эзэлхүүнтэй, 1цаг хэмжих үед)</b>		1.3	1.5	1.4	0.6	0.6
<b>Ундны усны зөвшөөрөгдөх хэмжээ MNS0900:2018</b>				100		

Хүрээлэн буй орчны цацрагийн хяналтын хүрээнд МУИС-н дэргэдэх Цөмийн физикийн судалгааны төвийн итгэмжлэгдсэн лабораториар уурхайн хөрс, хүдэр, хаягдал шороо дахь изотопуудын хувийн идэвх, элементийн агуулалт, шингэсэн тунгийн чадлыг жилд хоёр удаа тодорхойлуулсан.

Шинжилгээний дүнгээс харахад изотопуудын хувийн идэвх, элементийн агуулалт, шингэсэн тунгийн чадлын дундаж утга нь дэлхийн дундаж утгаас бага зэрэг их байна. Байгалийн цацраг идэвхт изотопууд нь хүрээлэн буй орчин болон улс орнуудад харилцан адилгүй байдаг. Монгол улс гэхэд баруун бүс, төвийн бүс, зүүн бүсүүдийн байгалийн цацраг идэвхт изотопууд харилцан адилгүй байна. Үүсмэл цацраг идэвхт изотоп  $^{137}\text{Cs}$  хувийн идэвх дэлхийн дунджаас 2-3 дахин бага байна.

Хүснэгт 38. Хөрс, хүдэр, хаягдал шороонд изотопуудын хувийн идэвх болон элементийн агуулалт, шингэсэн тунгийн чадлыг тодорхойлсон лабораторийн шинжилгээний дундаж утга

№	Дээжийн нэр	Изотопуудын хувийн идэвх, Бк/кг				Элементийн агуулалт			Шингэсэн тунгийн чадал, нГр/цаг
		$^{226}\text{Ra}$	$^{232}\text{Th}$	$^{40}\text{K}$	$^{137}\text{Cs}$	U, г/тн	Th, г/тн	К%	
1	Хөрс (130 цэгийн дундаж утга)	32.6	28.5	678	7.7	2.8	5.9	2.2	60.5
2	Хүдэр (40 цэгийн дундаж утга)	50.8	37.7	303.4	<1.1	3.9	4.73	1.6	Радийн эквивалент, Бк/кг
									126.7
3	Хаягдал шороо (10 цэгийн дундаж утга)	65.9	44.4	629.2	<1.1	5.47	10.88	2.11	Радийн эквивалент, Бк/кг
									177.2
4	Дэлхийн дундаж утга	25	25	370	27	2	5.2	1.4	Шингэсэн тунгийн чадал, нГр/цаг
									43
5	Баруун бүс дундаж утга	42.54	60.64	406.9	22.6	3.4	14.9	1.3	-
6	Төвийн бүс дундаж утга	24.7	21.0	802	26	2.4	2.1	0.8	-
7	Уурхайн орчмын хөрсний дэвсгэр түвшний судалгааны дундаж утга	34	14.5	690.7	34	2.8	3.5	2.3	53.8
8	Уурхайн орчмын хүдрийн дэвсгэр түвшний судалгааны дундаж утга	114.6	22	1015.3	-	9.4	5.4	3.2	229.6

## 9.5. УРГАМЛАН БҮРХЭВЧ, АМЬТНЫ АЙМГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

Ургамлан нөмрөгийн тархалт, бүрхэц, нягтшил, хэв шинж, зүйлийн бүрэлдэхүүн, амьтны төрөл зүйл, тоо толгой, шилжилт хөдөлгөөн, тархалтад хяналт-шинжилгээг “Итгэлт төгөл” ХХК-тай гэрээний дагуу хамтран ажилласан.

9.5.1. Хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх болон түүнд авах арга хэмжээ бүхий мэдээллийг тараах материал болон цахим хэлбэрээр нийт ажилтнуудад танилцуулсан. Мөн хэлтэс цехүүдийн мэдээллийн самбаруудад байрлуулсан.




Зураг 50. Хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлсэн тараах материал

## 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

10.1. Туслан гүйцэтгэгч аж ахуй нэгж байгууллага “ТМКМ” ХХК-ийн хүнд машин механизмын засварын гадна 3300 м<sup>2</sup> талбайг 08, 09-р саруудад бүрэн хатуу хучилттай болгосон. Хатуу хучилт тавих ажлын явцад өдөр тутмын засварын ажил хэвийн явагдсан.





Зураг 51. Хатуу хучилт тавих ажлын явц



*Зураг 52. Хатуу хучилт тавьсны дараах*

10.2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, 1500 модыг уурхайн бүсэд суулгасан. “ТМКМ” ХХК-ийн зүүн талд, аймаг явах зам дагуу, хэлтэс цехүүдийн гадна тохижилтонд улиас, голт бор, нарс, бургас болон суурьшлын бүс гүний усан санд жимсний төгөл байгуулахаар үхрийн нүдний суулгацыг суулгасан. Суулгалтын дараах усалгаа, арчилгааны ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн.



*Зураг 53. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн*

10.3. Дашбалбар сумын Цаг уурын өртөөний Хөдөө аж ахуйн ажиглалтын талбайн хашаажуулалтын ажлыг хийж гүйцэтгүүлэхээр “Мөнх ариун билиг” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Дашбалбар сумаас өгсөн хашааны загварын дагуу 25м:25м харьцаатайгаар хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгсөн.



*Зураг 54. Хөдөө аж ахуйн ажиглалтын хашаажуулалт*

10.4. Дашбалбар сумын Харзат багийн Хөх чулуутын булгийн эхийн хашаажуулалтын ажлыг хийж гүйцэтгүүлэхээр “Мөнх ариун билиг” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Дашбалбар сумаас өгсөн хашаажуулалтын загварын дагуу нүүлгэн шилжүүлэх боломжтой хөлт тулгууртай 40м:50м харьцаатайгаар хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгсөн.



*Зураг 55. Хөх чулуутын булгийн эхийн хашаажуулалт*

10.5. Дашбалбар сумын Улз голын эрэг дагуух “Улзын төгөл” ногоон байгууламжийн хашаажуулалтын ажлыг хийж гүйцэтгүүлэхээр “Мөнх ариун билиг” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Дашбалбар сумаас өгсөн хашааны загварын дагуу 100м:250м харьцаатайгаар хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгсөн.



Зураг 56. “Улзын төгөл” ногоон байгууламжийн хашаажуулалт

10.6. Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Дашбалбар сумын ЕБС-ийн “Гангар хун” эко клуб болон ЗДТГ-ын байгаль орчны тасагтай хамтран гар зургийн уралдаан, бүтээлийн уралдаан, илтгэлийн уралдаан зохион амжилттай байгуулсан. Уралдааны шагналын санг санхүүжүүлж, 03-р сарын 21-ний өдөр шагналт байрыг тодруулах, гардуулах үйл ажиллагаанд байгаль орчны инженерүүд оролцож, хамтран ажилласан.



Зураг 57. Шагнал гардуулах арга хэмжээ

10.7. Дашбалбар сумын ЕБС-ын С.Ариунцэцэг багштай “8а” ангийн “Байгаль орчин, эх дэлхийгээ хайрлая” сэдэвт хүүхэлдэйн жүжгийг 11-р сарын эхний 7 хоногоос эхлэн сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүд тоглохоор төлөвлөсөн. Хүүхэлдэйн жүжиг нь жүжигчилсэн бэлтгэл, хувцас хэрэглэлийн материал худалдан авах бэлтгэл шатандаа явж байгаа ба дүрүүдийн хувцас, хэрэглэлийн материалыг санхүүжүүлж, хамтран ажилласан.

10.8. Хэрлэн сумын гаалийн хяналтын бүсэд 35 ширхэг 105 метр урттай эвдэрсэн хашааг хурааж, талбайг чөлөөлсөн.



Зураг 58. Эвдэрсэн хашааг хурааж, талбайг чөлөөлсөн байдал

10.9. Хэрлэн сумын гаалийн хяналтын урд талын эвдэрсэн 700 м<sup>2</sup> талбайг хайрга шороогоор дүүргэлт хийж, тэгшилсэн.



Зураг 59. Талбайд дүүргэлт хийж, тэгшилэх ажлын явц

10.10. Баяжмал тэвээрлэлтийн гэрээт компаниудадын жолооч нарт “Өөрийн болон бусдын аюулгүй байдалд анхаарлаа хандуулж, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх” зорилгоор зөвлөмж бүхий тараах материалыг танилцуулсан.

Баяжмал тэвээрлэлтийн гэрээт компани нь ажлын явцад зөрчил гаргасан тохиолдолд тухай бүр нь албан бичгээр мэдэгдэж, арга хэмжээ авч ажиллаж байна.



Зураг 60. Гарын авлага танилцуулж буй нь

10.11. Хэрлэн сумын гаалийн хяналтын бүсийн гадна талбайд орчныг бохирдуулахаас сэргийлж ангилан ялгалтын хогийн сав байрлуулсан.

## 11. БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

11.1. 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан, хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал байгаль орчны хэлтсийн сар бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг. Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал байгаль орчны хэлтсийн 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг Дашбалбар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд хүргүүлсэн.

Дашбалбар сумын Засаг дарга, тамгын газрын мэргэжилтнүүд, иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 03-р сарын 25-ны өдөр “Шинь Шинь” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцахаар ирсэн. 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан, 2025 оны 1-р улирлын байдлаар хэрэгжилтийг танилцуулсан.



Зураг 61. Дашбалбар сумын ажлын хэсэг

11.2. Дорнод аймгийн Байгаль орчны газар, Дашбалбар сумын тамгын газар, Онон-Улз голын сав газрын захиргаанд тус тус 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг 11-р сард хүргүүлнэ.

11.3. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамд 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг 12-р сард хүргүүлнэ.

## 12. ДҮГНЭЛТ

АРГА ХЭМЖЭЭ	ЗАРДАЛ
<b>СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ</b>	
Усны машин ашиглан тоосжилт үүсэх замуудыг дулааны улиралд усалгааны хуваарь гарган усалгааг хийж гүйцэтгэсэн	Уурхайн зардлаас
Хүдэр ачих буулгах талбайг салхины нөлөөллөөс сэргийлсэн хаалт байгуулсан	Уурхайн зардлаас
Шаардлагагүй тохиолдолд тээврийн хэрэгслийг унтраах тухай мэдээлэл хүргэсэн	Уурхайн зардлаас
Агаарын сорьц цуглуулах гэрээний дагуу гадаад болон дотоод орчинд нийт 16 агаарын сорьц авч, нийт тоосонцорын шинжилгээ хийлгэхээр лаборатори луу илгээгээд байна	2'992'000
Ус хэмнэх шүршүүр суурилуулсан	Уурхайн зардлаас
Ус бохирдуулсны төлбөрийг улирал бүр төлдөг	Уурхайн зардлаас
Усны боломжит нөөцийн дүгнэлт, сав газрын ус ашиглуулах гэрээ, зөвшөөрөл зэрэгт тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлж ус ашиглалтын тайланд тусгадаг	Уурхайн зардлаас
Дэлхийн усны өдрийг тохиолдуулан “Гангар хун” эко клуб болон ЗДТГ-ын байгаль орчны тасагтай хамтран тэмцээн уралдаан зохион байгуулсан	Уурхайн зардлаас
Хаягдлын санд 2.3 га, далд уурхайн амны гадна 0.4 га талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн	Уурхайн зардлаас
Баяжмал тээвэрлэлтийн тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнийг GPS-ээр хянадаг	Уурхайн зардлаас
Төслийн хог хаягдлыг орон нутгаас зөвшөөрөгдсөн цэгт хог хаягдлын цэг үүсгэн зориулалтын дагуу ашигладаг	Уурхайн зардлаас
Уурхайн орчны хил хязгаарыг тэмдэгжүүлэх шав тэмдэгийг шинэчилсэн	Уурхайн зардлаас
Орчныг тохижуулж, уурхайн бүсэд ургамалжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн	Уурхайн зардлаас
Биологийн аргаар нөхөн сэргээх талбайд бэлчээрийн идэвхт ургамлыг тарьсан	Уурхайн зардлаас
Дуу шуугиан ихтэй ажлын байранд ажиллагсдыг сонсголын эрхтэн хамгаалах хэрэгслийг тогтмол олгодог	Уурхайн зардлаас
Нийт ажилтныг 11-р сард эрүүл мэндийн үзлэгт хамруулна	Уурхайн зардлаас
Өдөр бүр нийт ажилтанд хүнсний нэмэлт бүтээгдэхүүн олгодог	Уурхайн зардлаас
<b>ДҮН</b>	<b>2'992'000</b>
<b>НӨХӨН СЭРГЭЭЛТ</b>	
1.5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн	<b>9'825'000</b>
Техникийн нөхөн сэргээлт	Уурхайн зардлаас
Татан буулгах, хаалтад бэлтгэх	-
<b>ДҮН</b>	<b>9'825'000</b>
<b>ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ</b>	
Дүйцүүлэн хамгаалахаар орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газарт нутгийн байгаль хамгаалагчийг ажиллуулж байна (ажил гүйцэтгэхэд шаардлагатай урсгал зардал)	8'252'000
Ой хээрийн түймэр болон бусад байгалийн гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, гамшигийн үед яаралтай мэдээлэх утасны дугаартай мэдээллийн самбаруудыг байршуулж, байгалийн гамшиг тохиолдсон үед авах арга хэмжээний талаар нутгийн иргэдэд тараах материал, мэдээллийг хүргэсэн	Уурхайн зардлаас
Идэвхтэн байгаль хамгаалагч Сэвсүүл Жараахай багийн нутаг Зүүн сүүж, Галдан булаг орчмын ОНТХГазарт амьдарч байгаа болон нүүдэллэн өнгөрч байгаа амьтны аймгийн төрөл зүйлийн бүртгэлийг хөтөлдөг	Уурхайн зардлаас
Мардай тосгонд 8.1 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн	49'411'280
Дааврын булаг, Зээгийн өвөр гэх зэрэг газруудад нутагшуулсан тарваганы тооллого хийлгэсэн	Уурхайн зардлаас
<b>ДҮН</b>	<b>57'663'280</b>
<b>НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭ</b>	
<b>ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ</b>	
<b>ОСОЛ, ЭРСДЭЛИЙН ХИМИЙН БОДИСЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>	

Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах	Уурхайн зардлаас
Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулдаг	Уурхайн зардлаас
Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажилласан	Уурхайн зардлаас
Болзошгүй ослын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Уурхайн зардлаас
Хамгаалалтын хашааны ажлыг 06-р сарын 27- өдрөөс 07-р сарын 10-ны өдөр хүртэл гэрээнд заасан захиалагч талын хашаа барих ажилд тавигдах шаардлагын дагуу 100м:250м харьцаатайгаар хийж, хаягжуулж гүйцэтгэсэн болно.

Хавсралтаар Улз голын эрэг дагуух ногоон байгууламжийн хамгаалалтын хашааны ажлын гүйцэтгэлийн фото зургийг хавсаргав.

Хавсралт 1. хуудастай.

Хүлээлгэн өгсөн:

Гүйцэтгэгч тал:

М.Ариунмөр



"Мөнх ариун билиг" ХХК-ийн гүйцэтгэх захирал

Захиалагч тал:

Б.Уянга

*Б. Уянга*

"Шинь Шинь" ХХК-ийн ХЭМАББО-ы хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Амьдрал

*Б. Амьдрал*

"Шинь Шинь" ХХК-ийн ХЭМАББО-ы хэлтсийн байгаль орчны инженер

Хүлээн авсан:

Д.Тэгшээ

*Д. Тэгшээ*

Дашбалбар сумын "Дашбалбар хөгжил" ОНӨААТҮГ-ын захирал Д.Тэгшээ

М.Ганчимэг




Дашбалбар сумын байгаль хамгаалагч

Jul 12, 2025 at 4:55:09 PM



Jul 12, 2025 at 4:55:34 PM



## АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АКТ

2025 оны 07-р сарын 12-ны өдөр

Улааны уурхай

Дорнод аймгийн Дашбалбар сумын Цаг уурын өртөөний хөдөө аж ахуйн ажиглалтын талбайны хашааны ажлыг хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан.

Хашааны ажлыг 06-р сарын 26- өдрөөс 06-р сарын 27-ны өдөр хүртэл гэрээнд заасан захиалагч талын хашаа барих ажилд тавигдах шаардлагын дагуу 25м:25м харьцаатайгаар хийж, хаягжуулж гүйцэтгэсэн болно.

Хавсралтаар хөдөө аж ахуйн ажиглалтын талбайны хашааны ажлын гүйцэтгэлийн фото зургийг хавсаргав.

Хавсралт .1. хуудастай.

Хүлээлгэн өгсөн:

Гүйцэтгэгч тал:

М.Ариунмөр



“Мөнх ариун билиг” ХХК-ийн гүйцэтгэх захирал

Захиалагч тал:

Б.Уянга

Б. Уянга

“Шинь Шинь” ХХК-ийн ХЭМАББО-ы хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Амьдрал

Б. Амьдрал

“Шинь Шинь” ХХК-ийн ХЭМАББО-ы хэлтсийн байгаль орчны инженер

Хүлээн авсан:

Т.Бямбацэцэг

Т. Бямбацэцэг

Дашбалбар сумын Цаг уурын өртөөний дарга

М.Ганчимэг



Дашбалбар сумын байгаль хамгаалагч


Jul 12, 2025 at 5:09:30 PM



Jul 12, 2025 at 5:08:59 PM



Jul 12, 2025 at 5:09:03 PM



Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн 2025 оны жилийн мэдээ

1. Аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн хэсэг

Регистрийн дугаар	2	8	3	0	2	1	3
Аж ахуйн нэгж байгууллагын нэр	"Шинь Шинь" ХХК						
Байршил	Нэр			Код			
Аймаг, нийслэл	Дорнод			21			
Сум, дүүрэг	Дашбалбар			10			
2.Ерөнхий мэдээлэл							
Тусгай зөвшөөрлийн дугаар	000247А			00010089А			
Тусгай зөвшөөрлийн талбай, га	101.58			125			
Ашиглалт эхэлсэн он, сар, өдөр	2008						
Ашигт малтмалын төрөл	Цайр, Хар тугалга						
Ашиглалтын төрөл	Далд аргаар						

3.Уул уурхайн ашиглалт

Үзүүлэлт 指标	МД	Хэмжих нэгж	Нийт	Тайланд онд (Ашиглалт хийсэн)
А	Б	В	1	2
Олборлолтонд өртсөн нийт талбай	1		216.61×10 <sup>4</sup>	28.07×10 <sup>4</sup>
Ашигласан талбай	2	га		
Хаягдал чулуулгийн овоолго	3		5.7×10 <sup>4</sup>	1.5×10 <sup>4</sup>
	4	га		
Хөрсний овоолго	5			
	6			
Уул уурхайн дагалдах дэд бүтцийн нөлөөнд эвдэрсэн газар	7			
	8			
Бусад	9			

Үзүүлэлт 指标	МД	Хэмжих нэгж	Нийт	Техник	Биологи
А	Б	В	1	2	3
Байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан нөхөн сэргээлт хийх нийт талбайн хэмжээ	10	га		311	95
	11	мян.м3			
Тайлант онд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбай	12	га	9.6	8.1	1.5
	13	мян.м3			
Нөхөн сэргээлт нийт хийсэн талбай, мөр 14>мөр16, мөр15>мөр17	14	га			
	15	мян.м3			
Тайлант онд нөхөн сэргээлт хийсэн талбай	16	га	9.6	8.1	1.5
	17	мян.м3			
Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан нийт зардал мөр18>мөр19	18	мян.төг	197,421,980.00		
Тайлант онд нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан зардал	19	мян.төг	59,236,280.00	49,411,280.00	9,825,000.00
Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны нийт мөнгөн хөрөнгө, мөр20>мөр21	20	мян.төг	532,397,805.21		
Тайлант онд байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгө	21	мян.төг	154,692,605.21		
Байгаль хамгаалахад зарцуулсан нийт зардал, мөр 22>мөр 23	22	мян.төг	2,281,246,364.00		
Тайлант онд байгаль хамгаалахад зарцуулсан зардал	23	мян.төг			

Жич: 10 мөр уурхайн хаалт хийх үеийн талбайн хэмжээ 18-р мөр 22-р мөрнүүд 2017-2025 оны нийт зардлуудыг тусгасан болно.

Гүйцэтгэх захирал





УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ДҮГНЭЛТ

2014 оны 06 дугаар сарын 10

Дугаар 7/14-18-01

Улаанбаатар хот

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших MV-000247, MV-013555, MV-010089 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй Улаан, Мухарын холимог металлын ордыг далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-ийг хэлэлцсэн тухай

Шинь Шинь ХХК, Хунбөө ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төсөл, зөвлөх үйлчилгээний Рояал Рэнж ХХК-ийн боловсруулсан Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших Улаан, Мухарын холимог металлын ордыг далд аргаар ашиглах төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-д Монгол улсын зөвлөх инженер Ч.Цогтбаатар, Монгол улсын зөвлөх инженер Б.Элбэгзаяа зөвлөж, Монгол улсын зөвлөх инженер Б.Бямбадагва, Монгол улсын зөвлөх инженер Т.Батбаяр, Монгол улсын зөвлөх инженер Б.Чинзориг нар шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-ийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

2. Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь Төслийн танилцуулга, Ерөнхий мэдээлэл, Ордын геологийн судалгаа, Олборлолт, Хүдэр баяжуулах үйлдвэр, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөлмөр зохион байгуулалт, ажиллах хүч, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Зах зээлийн судалгаа, Төслийн эдийн засгийн үнэлгээ гэсэн нийт 11 бүлэг, 312 хуудас тайлбар бичиг, хавсралт 86 хуудас, нийт 398 хуудас, техник эдийн засгийн үндэслэлийн батлагдсан нүүр болон 32 ширхэг хавсралт зургуудаас бүрдэж байна.

3. Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших Улааны холимог металлын ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн ХХ-09-08 тоот дүгнэлт, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын н/115 тоот тушаалаар 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар Шинь Шинь ХХК-ийн эзэмшлийн MV-000247 тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах баттай (А) зэрэглэлийн нөөц 24.93 сая.тн, түүнд агуулагдах хар тугалганы нөөц 266.54 мян.тн,

цайрын нөөц 545.41 мян.тн, мөнгөний нөөц 1,160.3 тн, бодитой (В) зэрэглэлийн нөөц 11.26 сая.тн, түүнд агуулагдах хар тугалганы нөөц 101.2 мян.тн, цайрын нөөц 227.3 мян.тн, мөнгөний нөөц 478.3 тн, боломжтой (С) зэрэглэлийн нөөц 1.49 сая.тн, түүнд агуулагдах хар тугалганы нөөц 12.3 мян.тн, цайрын нөөц 27.7 мян.тн, мөнгөний нөөц 53.6 тн, Хунбөө ХХК-ийн эзэмшлийн MV-013555 тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах баттай (А) зэрэглэлийн нөөц 11.48 сая.тн, түүнд агуулагдах хар тугалганы нөөц 159.98 мян.тн, цайрын нөөц 215.56 мян.тн, мөнгөний нөөц 645.84 тн, бодитой (В) зэрэглэлийн нөөц 3.3 сая.тн, түүнд агуулагдах хар тугалганы нөөц 38.65 мян.тн, цайрын нөөц 73.03 мян.тн, мөнгөний нөөц 168.04 тн, боломжтой (С) зэрэглэлийн нөөц 0.46 сая.тн, түүнд агуулагдах хар тугалганы нөөц 5.32 мян.тн, цайрын нөөц 11.4 мян.тн, мөнгөний нөөц 24.8 тн гэж улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна.

4. MV-010089 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Мухарын холимог металлын ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2010 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн ХХ-01-03 тоот дүгнэлт, Ашигт малтмалын газрын даргын 2010 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 81 тоот тушаалаар 2009 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах холимог металлын хүдрийн бодитой (В) зэрэглэлийн нөөц 7.8 сая.тн, түүнд агуулагдах хар тугалганы нөөц бодитой (В) зэрэглэлээр 59.5 мян.тн, цайрын нөөц бодитой (В) зэрэглэлээр 257.5 мян.тн, мөнгөний нөөц бодитой (В) зэрэглэлээр 855.8 тн, боломжтой (С) зэрэглэлээр нөөцийг 2.98 сая.тн, түүнд агуулагдах хар тугалганы нөөц боломжтой (С) зэрэглэлээр 14.6 мян.тн, цайрын боломжтой (С) зэрэглэлээр 91.6 мян.тн, мөнгөний боломжтой (С) зэрэглэлээр 253.6 тн, хүдрийн бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 10.7 сая.тн, түүнд агуулагдах хар тугалганы нөөц бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр нөөцийг 74.1 мян.тн, цайрын нөөц бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 349.1 мян.тн, мөнгөний нөөц бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 1,109.4 тн гэж улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна.

5. Улааны ордын ашиглалтын үеийн хаягдал дунджаар 12%, бохирдолт дунджаар 13% байхаар тооцож 25.2 сая тонн холимог металлын хүдэр олборлох бөгөөд хар тугалганы 1.15% , цайрын 2.65%, мөнгөний 53.11г/тн, алтны 0.21г/тн тус тус агуулга бүхий 3.0 сая.тн хүдэр хаягдахаар байна. Үүнээс: Шинь Шинь ХХК-ийн MV-000247 талбайд хүдэр дахь алт 0.19г/тн, мөнгө 44.4г/тн, хар тугалга 0.94%, цайр 2.35%, кадми 0.01% тус тус эрдсийн агуулга бүхий 15.4 сая.тн хүдэр, Хунбөө ХХК-ийн MV-013555 талбайд хүдэр дахь алт 0.19г/тн, мөнгө 59.52г/тн, хар тугалга 1.43%, цайр 2.00%, кадми 0.01% тус тус эрдсийн агуулга бүхий 9.8 сая.тн хүдэр тус тус байна.

Мухарын ордын хувьд ашиглалтын үеийн хаягдал дунджаар 2.3%, бохирдол 7.2% байхаар тооцож 113.4 мян.тн хүдэр хаягдаж, хар тугалганы 0.69%, цайрын 3.03 % , мөнгөний 108.6 г/тн дундаж агуулга бүхий 5.2 сая.тн холимог металлын хүдэр олборлохоор тооцсон байна

Улааны ордын MV-000247 талбайгаас жилд дунджаар 600.0 мян.тн, MV-013555 талбайгаас жилд 300.0 мян.тн, Мухарын ордын MV-010089 талбайгаас жилд дунджаар 300 мян.тн хүдэр олборлон, жилд дунджаар 1200.0 мян.тн хүдэр баяжуулахаар төлөвлөжээ. Дээрх хүчин чадлаар Улаан, Мухарын холимог металлын ордыг ашиглах хугацаа нийт 29 жил байна.

6. Улаан, Мухарын ордыг налуу болон босоо амаар нээж, давхрын камераар нураах дүүргэлттэй ашиглалтын систем, дэд давхраар нураах дүүргэлттэй ашиглалтын систем, хоршоолон ашиглах дүүргэлттэй ашиглалтын системүүдийг хэрэглэхээр тусгасан байна.

7. Уурхайн үйлдвэрлэлийн процессуудад ашиглах тоног төхөөрөмжүүдийн бүтээл болон оновчтой тоо ширхгийн хэмжээг ордыг ашиглах аргаас хамааруулан хүдэр, хоосон чулуулаг ачилт, тээвэрлэлтэд Улааны далд уурхайд АСҮ-2С маркийн утгуурт ачигч, АСҮ307L маркийн утгуурт ачигч 4, 10тн даацтай 3157K2BE маркийн автосамосвал 9, 20тн даацтай TLK301B маркийн автосамосвал 9 зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар, Мухарын далд уурхайд ҮС6L290-20 маркийн автосамосвал 8, далд уурхайн ТСҮ-3 маркийн ачигч машин 2, далд уурхайн АГК-2 маркийн ачигч машин 2, далд уурхайн материал тээвэрлэлтэд ХҮҮЛ-5 маркийн машин 1, ажилчид тээвэрлэлтэд RU-20 маркийн машин 4, далд уурхайн өрөмдлөгийн ажилд Т-150 маркийн өрмийн машин 2, ҮТ-28 маркийн перфоратор 8, ҮСП-45 маркийн перфоратор 3, ҮГЗ-90 маркийн перфоратор 2, уурхайн газрын дээрх ажилд ZL50E маркийн дугуйт ачигч 1, бульдозер 1 зэрэг тоног төхөөрөмжийг ажиллуулахаар тус тус тооцоолсон байна.

8. Шинь Шинь ХХК-ийн Улааны ордын холимог металлын хүдрийн баяжигдах шинж чанарын судалгааг 2013 онд Эс Жи Эс Монгол ХХК-ийн лабораторид, 2014 онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн ШТЛ-той лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн түвшинд, БНХАУ-д 2023 онд тус тус хийж гүйцэтгүүлжээ.

Мухарын холимог металлын ордын дээжид баяжигдах шинж чанарын судалгааг 2009 онд БНХАУ-ын Ян Тай хотын "Шандун Хуанжин" группын Ян Тай зураг төслийн хүрээлэнд, 2015 онд Геологийн төв лабораторид тус тус гүйцэтгүүлсэн байна. Эдгээр лабораторид хийлгэсэн технологийн туршилтын үр дүн болон Улааны баяжуулах үйлдвэрийн бодит үр дүнд үндэслэн флотацийн аргаар баяжуулахаар төсөлд тусгажээ.

9. Мухарын ордын хар тугалга-цайрын хүдрийг Улааны холимог металлын уурхайн УБУ-т боловсруулах бөгөөд Шинь Шинь ХХК нь Мухарын ордын олборлолт эхлэх үед техникийн өргөтгөл хийж баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадлыг 1.2 сая.тн хүртэл нэмэгдүүлэхээр төлөвлөж төсөлд тусгасан байна.

Улааны ордын хүдрийг баяжуулж, төслийн нийт хугацаанд 515.90 мян.тн хар тугалганы баяжмал, 1,004.61 мян.тн цайрын баяжмал гаргах ба жилд дунджаар 15.79 мян.тн хар тугалганы баяжмал, 34.64 мян.тн цайрын баяжмал гаргахаар байна. Технологийн тооцооллоор 52% агуулгатай хар тугалганы баяжмалыг 94.27% металл авалттайгаар баяжуулах бол 50.6% агуулгатай цайрын баяжмалыг 91.11% металл авалттайгаар баяжуулах ба нийт баяжмал дахь мөнгөний металл авалт дунджаар 67.1% , алтны металл авалт дунджаар 50% байхаар тооцсон байна.

Мухарын ордын хүдрийн баяжуулалтаас гарах эцсийн бүтээгдэхүүн нь хар тугалганы баяжмал, цайрын баяжмал байх ба баяжмалуудад мөнгө дагалдан гарахаар тооцсон байна. Тооцооны үр дүнгээс харахад 60.1% агуулгатай хар тугалганы баяжмалыг 51% металл авалттайгаар баяжуулах бол 40% агуулгатай цайрын баяжмалыг 82% металл авалттайгаар баяжуулах ба нийт баяжмал дахь мөнгөний металл авалт 63% байхаар тооцож төслийн нийт хугацаанд 30.5 мян.тн хар тугалганы баяжмал, 321.5 мян.тн цайрын баяжмал гаргахаар байна.

10. Төслийн нийт хугацаанд 18.04 сая.м<sup>3</sup> ус ашиглахаас баяжуулах үйлдвэрт 16.9 сая.м<sup>3</sup>, хотхоны хэрэгцээнд 884 мян.м<sup>3</sup>, далд уурхайд 259.2 мян.м<sup>3</sup> ус тус тус ашиглах бөгөөд Сэвсүүлийн голын хөндийн газар доорх усны нөөцөөс 9 гүний худаг гаргах ус татах замаар хангахаар тусгасан байна. Төслийн цахилгаан хангамж Дорнод бүсийн эрчим хүчний түгээх сүлжээнд холбогдон хангагдсан бөгөөд БНХАУ-д үйлдвэрлэсэн ZJRX1600PG2 маркийн 1600 кВт хүчин чадалтай 3 ширхэг дизель цахилгаан үүсгүүрийг эрчим хүчний нөөц эх үүсгэвэр болгон ашиглаж байна.

11. Уг төслийг хэрэгжүүлснээр 804 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 2.3 сая төгрөг байхаар байна

12. Байгаль орчныг хамгаалах зардалд 6,032.0 сая төгрөг, хаалтын зардалд 4,300.0 сая төгрөгийг тус тус зарцуулахаар тусгажээ. Үүнээс бэлтгэл ажлын зардалд 210 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлт 50.9 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 176.5 сая төгрөг, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 123.2 сая төгрөг, дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн зардалд 1.9 тэрбум төгрөг, байгаль орчны менежментийн зардалд 2.4 тэрбум төгрөг, орчны хяналт шинжилгээний зардалд 1.0 тэрбум төгрөг тус тус зарцуулахаар төсөлд тусгажээ

13. Уурхайн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 307.3 тэрбум төгрөг буюу 99.6 тэрбум төгрөгийг далд уурхайн тоног төхөөрөмж, 58.8 тэрбум төгрөгийг баяжуулах үйлдвэрт, 98.2 тэрбум төгрөгийг уурхайн дэд бүтэц, тосгоны барилга байгууламж, сайжруулсан шороон зам тавих хөрөнгө оруулалт, далд уурхайн дүүргэлтийн системд 11.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр тооцжээ. Элгэдэл хорогдлын шимтгэлийн зардалд нийт 52.8 тэрбум төгрөг байхаар тооцоолсон байна.

14. Төслийн нийт хугацаанд 11,065.0 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 5,515.7 тэрбум төгрөгийн зардал гарган, 5,295.1 тэрбум төгрөгийн татварын өмнөх, татварын дараах 3,997.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт төслийн хугацаанд 2,049.5 тэрбум төгрөгийг татвар төлбөр хэлбэрээр төвлөрүүлэхээр тусгажээ. Төслийн хугацаанд 1 тн баяжмалын бүрэн өөрийн өртөг 4 сая төгрөг байна.

15. Төслийн 29 жилийн хугацаанд нийт 4,088.4 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд өнөөгийн цэвэр үнэ цэн (NPV, @10%) 1,004.3 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 64%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 2 жил байна.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник, эдийн засгийн үндэслэлийн захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна. Үүнд:

1. Төсөл захиалагч нь ордын хэмжээнд бүртгэгдсэн цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах судалгаа хийж, технологийн шийдэл, эдийн засгийн үр ашиг, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн тооцоолол боловсруулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд 2025 оны хоёрдугаар улиралд багтаан танилцуулах;
2. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах;
3. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;
4. Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-д тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан болон усан хангамж, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төсөл, зөвлөх үйлчилгээний Роял Рэнж ХХК, түүний үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан Монгол улсын зөвлөх инженер Б.Бямбадагва, Монгол улсын зөвлөх инженер Т.Батбаяр, Монгол улсын зөвлөх инженер Б.Чинзориг нар тус тус хариуцах.

Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-д хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших MV-000247, MV-013555, MV-010089 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй Улаан, Мухарын холимог металлын ордыг далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-ийг бүртгэн авах;
2. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэйг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;
3. Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших MV-000247, MV-013555, MV-010089 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй Улаан, Мухарын холимог металлын ордыг далд аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1, түүнийг хуулсан диск, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн ажлын 5 өдөрт багтаан хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

М.МЭНДБАЯР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

С.ТАН-ОЧИР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ХУЛАН



8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	5								
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5								
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5								
	Нийт оноо	100								

Тайлбар: Бүрэлдэхүүн хэсэг тус бүрт биелэлтээс нь хамааран авсан байвал зохих оноог тогтоосон ба ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн онооны энгийн арифметик дунджийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тооцож гаргана. Гишүүдийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт өгсөн онооны энгийн арифметик дунджийн хийлбэр нь нийт оноо болно. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн биелэлтийн оноо нь 90-ээс доош байвал төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй гэж үзнэ. Тухайн жилд дүйцүүлэн хамгаалах ажил төлөвлөгдөөгүй бол нөхөн сэргээх арга хэмжээ рүү, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй бол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт рүү шилжүүлж тооцно.

**Ажлын хэсгийн дарга:** \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

**Гишүүд:**

Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Байгаль орчны асуудал хариуцсан газрын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Сав газрын захиргааны ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

**Хүлээн зөвшөөрсөн:**

\_\_\_\_\_ ХХК-ийн захирал



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ДҮГНЭЛТ

2018 оны 04 сарын 05 өдөр

Дугаар XX-09-08

Улаанбаатар хот

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших  
“Улаан”-ы холимог металлын ордын  
MV-000247, MV-013555 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах  
нөөцийн шинэчилсэн тооцооны үр дүнгийн тайланг  
хэлэлцсэн тухай

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших “Улаан”-ы холимог металлын ордод 1983-1986 онуудад хийгдсэн нарийвчилсан хайгуулын ажлын үр дүн, “Шинь Шинь” ХХК болон “Хунбөө” ХХК-ийн гүйцэтгэсэн олборлолтын бэлтгэл ажлын үеийн геологийн чиглэлийн мэдээллийг ашиглан нөөцийг шинэчлэн тооцоолох ажлыг Монгол Улсын зөвлөх инженер, геологич, доктор О.Чулуун, Монгол Улсын зөвлөх геологич, доктор, профессор Д.Даваасамбуу, геологич Д.Сосорбарам, Ч.Мижиддорж нарын боловсруулсан тайлан, уг тайлан дахь нөөцийн тооцоо, уул техникийн нөхцөл, эдийн засгийн урьдчилсан үнэлгээнд Монгол Улсын зөвлөх инженер, ШУ-ны доктор Ч.Тэгшсайхан, Монгол Улсын зөвлөх геологич, доктор Д.Доржготов, мэргэшсэн геологич Д.Сүхбазар нарын хийсэн шинжээчийн дүгнэлтүүдийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших “Улаан” нэртэй 101 га талбайн MV-000247 дугаар тусгай зөвшөөрлийг “Шинь Шинь” ХХК-д 2007 оны 01 сарын 23-ны өдөр, “Мухар-1” нэртэй нийт 25 га талбайн MV-013555 дугаар тусгай зөвшөөрлийг “Хунбөө” ХХК-д 2008 оны 04 сарын 16-ны өдөр ГУУКА-ы даргын шийдвэрээр тус тус олгосон байна. “Шинь Шинь”, “Хунбөө” ХХК-иудын хооронд 2011 оны 9 сарын 13-ны өдөр байгуулсан 11\03 дугаар хамтран ажиллах гэрээний дагуу “Шинь Шинь” ХХК нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг.

“Улаан”-ы холимог металлын орд нь Улаанбаатар хотоос зүүн хойд зүгт 790 км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос хойд зүгт 130 км, Дорнод аймгийн Дашбалбар сумын төвөөс баруун урд зүгт 70 км зайд оршино.

2. “Шинь Шинь” ХХК нь дээр дурдсан ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайнуудад 2016-2017 онуудад олборлолтын бэлтгэл ажлын явцад хяналтын сорьцлолт, технологийн туршилт, байр зүйн зураглалын ажил зэрэг ажлуудыг гүйцэтгэн, нөөцийн шинэчилсэн тооцоо хийж, 1.9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

3. “Улаан”-ы холимог металлын ордыг 1973 онд Монголын геологи зураглалын экспедиц Дорнодын хүдрийн районд эрэл-үнэлгээний ажил гүйцэтгэх явцдаа анх илрүүлэн, 1973-79 онд эрэл-үнэлгээний, 1980-83 онд урьдчилсан хайгуулын, 1984-86 онд нарийвчилсан хайгуулын ажлуудыг гүйцэтгэсэн.

Дээрх ажлуудын үр дүнгээр БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын ашигт малтмалын нөөцийн комиссын 1989 оны 11 сарын 30-ны өдрийн 33 дугаар тогтоолоор ордын балансын нөөцийг В, С<sub>1</sub>, С<sub>2</sub> зэргээр 38.1 сая тн хүдэрт, цайрын нөөцийг 738,4 мян.тн, хар тугалганы нөөцийг 418.6 мян.тн, мөнгөний нөөцийг 1959 тн-оор, балансын бус нөөцийг С<sub>1</sub>, С<sub>2</sub> зэргээр 37.6 сая тн хүдэр, түүн дэх цайрыг 563.9 мян.тн, хар тугалга 331.8 мян.тн, мөнгө 1453 тн, нийт нөөцийг 75.7 сая.тн хүдэрт цайрын 1302.3 мян.тн, хар тугалганы 750.4, мөнгөний 3412тн

нөөцийг тус тус хүлээн авсан байна. Мөн алт, кадми, сульфидын хүхэр, ураны нөөцийг бүртгэн авчээ.

4. “Шинь Шинь” ХХК нь “Улаан”-ы ордын шинэчилсэн нөөцийн тооцооллыг хийхдээ тус ордод ЗХУ-ын \хуучин нэрээр\ Монголын геологи, зураглалын экспедицээс 1980-86 онуудад Улааны холимог металлын ордод гүйцэтгэсэн урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын ажлын нөөцийн тооцоолол бүхий үр дүнгийн тайлан, хайгуулын ажлын явцад дээрх байгууллагаас ОХУ-ын Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд гүйцэтгүүлсэн технологийн судалгааны үр дүнгийн тайлангууд, “GPSS” ХХК-иар 1:2000 масштабтай байр зүйн зураглалын ажил, “SGS Монгол” ХХК, “Эрдэнэтийн УБҮ”-ийн Улааны ордын хүдэрт хийсэн технологийн туршилтын ажлууд, 2016-2017 онуудад олборлолтын бэлтгэл ажлаар 9 түвшинд нэвтэрсэн далд малталт-хэвтээ штрекүүдээс 6300 ш сорьцод хийсэн лабораторийн хяналтын ажлын үр дүнд тулгуурласан байна.

5. Улааны холимог металлын орд нь Төв Монголын атираат тогтолцооны Идэрмэгийн террейний зүүн хойд талыг хамаарах Умард-Чойбалсангийн хүдрийн дүүрэгт оршдог. Геологийн тогтцын хувьд Дорнод Монголын вулкан-тектоник структурын Улааны блокийн зүүн-хойд зах Дорнодын вулкан-тектоник структурт байрших ба энэхүү структурыг дүүргэж байгаа хожуу мезозойн (дээд юра-доод цэрд) вулкан-тунамал бүрдлийг (Монголын геологи ба ашигт малтмал, боть 1, Стратиграфи, 2012) анх судалгаа хийж ялгасан Монголын геологийн зураглалын экспедици нь 3 хэсэг буюу дэд бүрдэлд хувааж байсныг 1995 онд Т.Биндэръяа, П.Хосбаяр нар Баянтүмэн формац гэж ангилан 3 мэмбэрт хуваан авч үзсэн байна.

Хүдэр агуулагч гол структур нь өргөргийн дагуу чиглэлтэй босоо уналтай сулралын бүс, Мухарын, зүүн Мухарын хагарлын огтлол дээр үүссэн бараг эгц уналтай дэлбэрэлтийн хоолой юм. Ордын хэмжээнд өмнөх судлаачид бараг босоо уналтай судал, багана маягийн хэлбэртэй, суналын дагуу 100-400 м, уналын дагуу 100-700 м үргэлжлэх 9 биетийг тогтоон нөөцийг тооцоолсон. Хүдрийн биетүүдийн дотоод бүтэц, агуулагч чулуулаг, хүдэржилт үүссэн нөхцөлүүд нэг учраас харьцангуй энгийн, хүдэржилтийн хил хязгаар нь бараг геологийн хилтэй давхцадаг байна. Нөөцийн тооцооны жишиг үзүүлэлтэд үндэслэн, ЗХУ-ын геологчидийн ялгасан 1, 2, 5, 5а, 6, 9, 9а-р биетүүдийг 5-р биет \үндсэн тэсрэлтийн хоолой\, 12 дугаар биетүүдийг 9 дүгээр биет \судлын биет\, 10 дугаар биетийг 10 дугаар биет \үндсэн хоолойгоос зүүн тийш байрлах Зүүн хоолой\ гэж ялган авч үзжээ.

“Улаан”-ы холимог металлын орд нь ордын нийлмэл тогтцын ангиллаар 2-р зэргийн ордод хамаарна. Орд нь галенит сфалеритын эрдсийн төрлийн, мөнгө, алт агуулсан холимог металлын хүдрээр илэрхийлэгдэнэ. Гол ашигт малтмал нь цайр, хар тугалга, мөнгө бөгөөд дагалдах ашигт малтмал нь алт, кадмий. Хүдэрт цайр нь сфалеритаар, хар тугалга нь галенитаар, мөнгө нь галенитэд, алт нь сульфидууд болоод кварцад, кадмий нь сфалеритад тус тус агуулагдаж байна. Хүдэр нь анхдагч хүдрээр илэрхийлэгдэх ба гадаргуугаас 20-30 м хүртэл сулхан исэлдсэн исэлдлийн бүс тогтоогдоно.

6. Урьдчилсан, нарийвчилсан хайгуулын, олборлолтын бэлтгэл ажлын явцад авсан сорьцуудад хар тугалга, цайр, мөнгөний агуулга тодорхойлох шинжилгээг атом шингээлтийн аргаар 21490 сорьцод хийсэн бөгөөд геологийн болон лабораторийн дотоод, гадаад хяналтаар шинжилгээний үр дүнгүүдийн зөрөө зохих хязгаарын хэмжээнээс хэтрээгүй тул ямар нэгэн тохиолдлын ба системтэй алдаа тогтоогдоогүй байна.

300 кг сорьц дээр “SGS Монголиа” ХХК-ийн лабораторид технологийн туршилт явуулж, 62.8%-ийн хар тугалга агуулсан 92.93%-ийн металл авалттай хар тугалганы баяжмал, 41.61%-ийн цайр агуулсан 84.84%-ийн металл авалттай цайрын баяжмал тус тус гарган авах боломжтой гэж үзжээ.

7. Зохиогчид “Улаан”-ы ордын нөөцийг +1125-1065, +1065, +1005 м, +945 м, +885 м, +825 м, +765 м, +705 м, +645 м-ийн түвшнүүдэд А, В, С зэргээр 0-1.8, 1.8-3.0, 3.0-3.7, 3.7-4.7, >4.7% гэсэн цайрын эквивалент агуулгын интервалд хуваан, энгийн Кригингийн аргаар бодож, урвуу зайн аргаар шалгасан байна.

“Улаан”-ы ордын шинэчилсэн тооцооллын ажлаар ордын хэмжээнд баттай (А) зэргийн 37477038 тн хүдэрт 443074 тн хар тугалганы, 787785 тн цайрын, 1862681 тн мөнгөний, бодитой (В) зэргийн 15858500 тн хүдэрт 157493 тн хар тугалганы, 329770 тн цайрын, 696167 тн мөнгөний,

боломжтой (С) зэргийн 2392470 тн хүдэрт 23452 тн хар тугалганы, 48845 тн цайрын, 92516 тн мөнгөний, нийт 55,728,008 тн хүдэрт 624019 тн хар тугалганы, 1166400 тн цайрын, 2651364 тн мөнгөний нөөц тооцоолсон. /Хавсралт №4/ Мөн алтны нөөцийг 9079.56 кг, кадмийн нөөцийг 4539.7 тн, ураны нөөцийг 174 тн гэж шинэчлэн тооцоолжээ.

MV-000247, MV-013555 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах баттай (А) зэргийн 36411646 тн хүдэрт 426520 тн хар тугалганы, 760963 тн цайрын, 1806096 тн мөнгөний, бодитой (В) зэргийн 14566156 тн хүдэрт 139818 тн хар тугалганы, 300366 тн цайрын, 646315 тн мөнгөний, боломжтой (С) зэргийн 1950885 тн хүдэрт 17606 тн хар тугалганы, 39051 тн цайрын, 78483 тн мөнгөний, нийт 52,928,687 тн хүдэрт 583944 тн хар тугалганы, 1100380 тн цайрын, 2530894 тн мөнгөний нөөц тооцоолсон байна.

Тусгай зөвшөөрлийн талбайн гадна байгаа нөөцийг баттай (А) зэргээр 1065393 тн хүдэрт 16555 тн хар тугалга, 26822 тн цайр, 56585 тн мөнгө, бодитой (В) зэргээр 1292344 тн хүдэрт 17674 тн хар тугалга, 29405 тн цайр, 49852 тн мөнгө, боломжтой (С) зэргээр 441585 тн хүдэрт 5846 тн хар тугалга, 9794 тн цайр, 14033 тн мөнгө, нийт 2799321 тн хүдэрт 40075 тн хар тугалга, 66021 тн цайр, 120470 тн мөнгө гэж тооцжээ. Хавсралт №5

Шинжээч дээрх нөөцийн тооцоонд хяналтын тооцоо хийж геостатистик аргаар тооцоолсон нөөцийн зөрүү 0.14% байгаа нь зөвшөөрөгдөх хэмжээ тул зохиогчдын тооцсон хувилбараар цайр, хар тугалга, мөнгөний нөөцийг хүлээн авахыг санал болгосон.

ЭБМЗ-ийн хуралдаанаар гишүүд шинжээчийн санал болгосноор зохиогчийн шинэчлэн тооцсон хувилбараар цайр, хар тугалга, мөнгөний нөөцийг хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын ашигт малтмалын нөөцийн комиссын 1989 оны 11 сарын 30-ны өдрийн 33 дугаар тогтоолоор хүлээн авсан алт, кадми, уран, сульфидын хүхрийн нөөцийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзэв.

8.Улааны холимог металлын ордын нөөцийн тооцоололд дараах нөөцийн жишиг үзүүлэлтүүдийг хэрэглэсэн байна. Үүнд:

- хүдрийн биетийг үүсгэх эквивалент цайрын захын агуулга 1.8%,
- эквивалент цайрын үйлдвэрлэлийн хамгийн бага агуулга 3.0% ,
- хүдрийн биет үе-ийн хамгийн бага зузаан 2.0 м,

9.Ордын орчимд гадаргуугийн урсгал ус болон усан хуримтлал байхгүй. Гүний ус нь хагарал бутралын бүсэд хуримтлагдсан, сульфат-гидрокарбонатын найрлагатай, усан дахь хар тугалга, цайрын агуулга 1-1.4 мг/л тул хүнсэнд хэрэглэхэд тохирохгүй, харин техникийн зориулалтаар ашиглах боломжтой, ус дамжуулах дундаж коэффициент 3.6 м<sup>2</sup>/хоног, ус дамжуулах түвшин 2000 м<sup>2</sup>/хоног.

10.Ордыг ашиглах эдийн засгийн урьдчилсан үнэлгээгээр эхний 22 жилд 19.2 сая тн хүдэр олборлож, 900000 тн хүдэр боловсруулах бөгөөд энэ хугацаанд 10%-ийн шилжүүлэх нормоор 83210.0 сая төгрөгийн өнөөгийн цэвэр ашигтай, 16.5%-ийн өгөөжийн дотоод нормтой ажиллаж, хөрөнгө оруулалтаа 5.8 жилийн дотор нөхөн, 538,038.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тооцоолсон ба байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд нийт 16,847.0 сая төгрөг зарцуулна гэж тусгажээ.

11. Цаашид Монгол Улсын хууль, дүрэм журам, заавар, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нөөцийн ангиллуудыг мөрдөж ажиллах, “Улаан”-ы ордын ураны хүдрийг хамгаалалтын цулд түр хадгалах тухай гэрээнд тусгагдсан хилийн гадна талд байгаа ураны хүдрийн биетүүдийн зарим хэсэг нь хамаарагдахгүй байгаа тул солбицлыг шинэчлэн гэрээнд тусгах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон ордыг ашиглах ТЭЗҮ-ийг эрх бүхий хуулийн этгээдээр хийлгэх, олборлолтын үед хүдэр дэх алт, кадми, ураны агуулгад хяналт тавьж ажиллах, цацраг идэвхт ашигт малтмалын чиглэлээр судалгаа хийх, олборлолтын тайлан мэдээг цаг хугацаанд холбогдох хэлтэст ирүүлж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд анхааруулахаар тогтов.

*Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.3 дахь хэсэг,*

энэхүү дүгнэлт болон холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг АМГТГ-ын даргад уламжлахаар шийдвэрлэв.

Нэг. Дорнод аймгийн Дашбалбар сумын орших “Улаан”-ы холимог металлын ордын нөөцийг шинэчлэн тооцоолсон ажлын үр дүнгийн тайлан /ордын нөөц 2018 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар/ дахь MV-000247, MV-013555 тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах баттай (А), бодитой (В) болон боломжтой (С) зэргээр хүдрийн нөөцийг 52928687 тн, түүн дэх хар тугалганы нөөцийг 583944 тн, цайрын нөөцийг 1100380 тн, мөнгөний нөөцийг 2530894 тн гэж хүснэгт №1-3-ын дагуу хүлээн авах.

Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан “Улаан”-ы холимог металлын ордын нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв /Н.Мөнхбилэг/-д зөвшөөрөх.

Гурав. Дээрх нөөцийг хүлээн авсантай холбогдуулан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Улсын ашигт малтмалын нөөцийн комиссын 1989 оны 11 сарын 30-ны өдрийн 33 тоот тогтоолоор хүлээн авсан “Улаан”-ы ордын MV-000247, MV-013555 тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах олборлоод бүртгэлд үлдсэн нөөцийг Улсын нэгдсэн тоо бүртгэлээс хасаж, нөөцийн хөдөлгөөн хийхийг Эрдэс баялгийн мэдээлэл, технологийн төв /Н.Мөнхбилэг/-д зөвшөөрөх.

Дөрөв. Энэхүү дүгнэлтийн 11 дүгээр заалтыг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Шинь Шинь” ХХК /Ли Жэн/ болон “Хунбөө” ХХК /Р.Хурцбаяр/-д анхааруулах.

Тав. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэрийг дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГТГ-ын даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан, Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг “Шинь Шинь” ХХК /Ли Жэн/-д даалгах.

Зургаа. “Улаан”-ы холимог металлын ордын нөөцийн шинэчлэн тооцооны ажлын чанарыг зөвлөх инженер, геологич, доктор О.Чулуун, зөвлөх инженер, геологич, доктор, профессор Д.Даваасамбуу, мэргэшсэн инженер, геологич Д.Сосорбарам, геологич Ч.Мижиддорж нар, тайлангийн үнэн зөв байдал, чанарыг хянаж гаргасан шинжээчийн дүгнэлтийг зөвлөх инженер, геологич, доктор Д.Доржготов, зөвлөх инженер, шинжлэх ухааны доктор Т.Тэгшсайхан, мэргэшсэн инженер, геологич Д.Сүхбазар нар болон “Шинь Шинь” ХХК тус тус хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ

ДАРГА

А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ЦАЦРАЛ

# УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙСЭН ХАЙГУУЛЫН ЗАРДАЛ НӨХӨН ТӨЛӨХ ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ТУХАЙ АКТ

Дугаар 2007/02

2007.01.31.

Улаанбаатар хот

АМГТХЭГ болон ШИНЬ ШИНЬ ХХК- ийн хооронд 2006 оны 6 дугаар сарын 05 - ны өдөр байгуулсан ХАЗ – 2006 – 10/102 тоот гэрээг хоёр тал хамтран дүгнэв.

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших Улааны холимог металлын ордод улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардал болох 1302205,0 (Нэг сая гурван зуун хоёр мянга хоёр зуун таван) ам.долларыг Шинь Шинь ХХК нь нөхөн төлбөрөө 2006 – 2007 онд бүрэн төлж дуусгасан тул энэхүү актыг үйлдэв.

Хоёр тал гэрээг хамтран дүгнээд Шинь Шинь ХХК – ийг гэрээт үүргээ хугацаанд нь хангалттай биелүүлсэн гэж үзэв.





2006 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1	-			
2	390661.0		390661.00\$	2006.06.08
3	-			
4	-			

2007 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1	-			
2	113943.0		227886.0 \$	2007.01.08
3	-			
4	113943.0			

2008 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1	-			
2	113943.0		227886.0 \$	2007.01.08
3	-			
4	113943.0			

2009 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1	-			
2	113943.0		227886.0 \$	2007.01.08
3	-			
4	113943.0			

2010 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1	-			
2	113943.0		227886.0 \$	
3	-			
4	113943.0			

Төрөөнгэ засгуулан төлөв дүрэн дийг-  
Солгооч! 2007 оны үүнэсөн ажил.  
2007.02.25. нөт 9078

2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн  
А/439 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

“ЭВДЭРСЭН ГАЗАРТ НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН  
ГАЗРЫГ ХҮЛЭЭЖ АВАХ АКТ”

№02

2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр

1. Байршлын мэдээлэл		
1.1.	Аймаг, нийслэлийн нэр	Дорнод
1.2.	Сум, дүүргийн нэр	Дашбалбар
1.3.	Газрын нэр	Дашбалбар сумын нутаг Мардай хуучин тосгоны сууршлийн бүсэд эвдэрч эзэнгүй орхигдсон газар
2. Нөхөн сэргээлт хийсэн байгууллагын мэдээлэл		
2.1	Нөхөн сэргээлт хийсэн аж ахуй нэгжийн нэр, регистр	“Шинь Шинь” ХХК РД: 2830213
2.2	Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	сая төгрөг /компани хөрөнгө/
2.3	Тус газрын эвдрэлд өртсөн шалтгаан	Дашбалбар сумын нутаг Мардай хуучин тосгоны өмч хувьчлалаар хөрөнгийг хувааснаар эзэмшигч иргэн, хуулийн этгээдүүд барилга байгууламжийг нурааж, шугам хоолойг ухаж авсны улмаас эвдэрч орхигдсон газар
2.4	Тус талбайд нийт эвдрэлд өртсөн талбайн хэмжээ (га)	185 га
2.5	Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрхтэй эсэх, зөвшөөрлийн дугаар	Ашигт малтмалын MV-000247, MV-00010089 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн “Шинь Шинь” ХХК 2025 оны дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний хүрээнд техник, биологийн нөхөн сэргээлтийн ажлыг өөрийн техник, хүн хүч, хөрөнгөөр хийсэн.
3. 2023 онд хүлээлгэн өгч буй нөхөн сэргээлтийн мэдээлэл		
Техникийн нөхөн сэргээлт	Биологийн нөхөн сэргээлт	
- Талбайн хэмжээ: 8.1 га	- Талбайн хэмжээ: 1.5 га	
- Зардлын хэмжээ: 49411280 төг	- Биологийн нөхөн сэргээлтэд ашигласан мод, сөөг, ургамлын зүйлийн нэр, ургамалжуулсан байдал: -саман ерхөг, соргүй согоовор -ботууль, царгас -Нийт 162.5 кг - Зардлын хэмжээ: 9825000 төг	
4. Орон зайн мэдээлэл		
4.1 Нөхөн сэргээлт хийгдсэн	4.2. Хэмжилт, зураглал	

газрын фото зураг	<p>-Кадастрын зураглал хийсэн мэргэжлийн байгууллага болон хэмжилт хийсэн хүний нэр:</p> <p>-Аймгийн Байгаль орчны газрын мэргэжилтэн Н.Сүх-Ялалт</p> <p>-Хэмжилтэд ашигласан программ, тоног төхөөрөмж:</p> <p>-GPS гар багажаар координатын цэг авч, Google earth зураг дээр тэмдэглэл хийсэн.</p> <p>- Холбогдох утас: 88134564</p> <p>Гарын үсэг: .....</p> <p>.....</p>
<p>4.3 Нөхөн сэргээлт хийсэн газрын солбицол</p> <p>Жич: 4-өөс доошгүй эргэлтийн цэгийн солбицол байна.</p>	<p>- Олон байршилд нөхөн сэргээлт хийсэн тул солбицолыг хавсралтаар хавсаргав.</p>
<p>Нөхөн сэргээлт хийсэн газарт хэмжилт хийж талбайн хэмжээг тогтоон полигон хэлбэрээр shape.file үүсгэн флаш болон CD-нд хуулж акттай хавсаргана.</p>	
<p><b>5. Мэдээллийн сангийн бүртгэл</b></p>	
<p>Нөхөн сэргээлтийг хүлээн авсан ажлын хэсэг нь Байгаль орчны мэдээллийн сангийн <a href="http://www.oic.mn">www.oic.mn</a> цахим системийн Нөхөн сэргээлтийн мэдээллийн дэд санд заавал бүртгүүлнэ.</p>	
<p>Жич: Мэдээллийн санд бүртгээгүй тохиолдолд нөхөн сэргээлтийг хүлээн авсан актыг хүчинтэйд тооцохгүй.</p>	
<p>Мэдээлэл оруулсан хүний нэр, албан тушаал: Н.Сүх-ялалт, Байгаль орчны газрын газар зүйн мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн.</p>	
<p>Гарын үсэг:</p>	
<p>Огноо:</p>	
<p>Нэмэлт мэдээлэл:</p>	

Нөхөн сэргээлтийн ажил нь холбогдох хууль, журам, стандартад нийцсэн талаарх ажлын хэсгийн дүгнэлт:

“Шинь Шинь” ХХК-ийн 2025 онд хүлээлгэн өгч байгаа нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг аймгийн Засаг даргын 2020 оны А/500 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн газар дээр нь хянаж, хэмжилт хийн ажилласан.

Гүйцэтгэсэн нөхөн сэргээлт нь Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, MNS5917:2008, MNS5918:2023 стандартын шаардлагыг хангаж байна.


Тиймээс ажлын хэсгийн гишүүдийн 100 хувийн саналаар “Шинь Шинь” ХХК-ийн гүйцэтгэсэн 9.1 га талбайн техникийн нөхөн сэргээлт, 1.5 га талбайн биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг актаар хүлээн авахаар шийдвэрлэсэн.


АКТИЙН АРСАН:

Ажлын хэсгийн дарга:  ..... -Аймгийн Байгаль орчны газрын дарга  
А.Гантулга

Нарийн бичгийн дарга:  ..... -Аймгийн Байгаль орчны газрын  
Н.Сүх-Ялалт мэргэжилтэн


Гишүүд:

Х.Энххэрлэн  ..... -Аймгийн Байгаль орчны газрын  
байгаль орчны хяналтын улсын байцаагч

И.Алтмаа  ..... -Онон Улз голын сав газрын  
Захиргааны мэргэжилтэн

Ю.Мөнхтөмөр  ..... -Дашбалбар сумын байгаль хамгаалагч

Б.Цогтсайхан  ..... -1 дүгээр Багийн Засаг дарга

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:  ..... "Шинь Шинь" ХХК-ийн ХЭМБББХэлтсийн  
Ван Мин Шань Дарга  
Б.Амьдрал  ..... "Шинь Шинь" ХХК-ийн ХЭМБББХэлтсийн  
Байгаль орчны мэргэжилтэн

---oOo---

Байгаль орчин, аялал жуучлалын сайдын  
2019 оны А/618 дугаар журмын 4 дүгээр  
хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭСЭН АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭХ ХУУДАС.

Дугаар: 01

Огноо: 2025-11-06

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа "Шинь шинь" ХХК-ийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт /.....<sup>94</sup>...../ хувьтайгаар дүгнэгдлээ.

Дорнод аймгийн Засаг даргын 2020 оны А/500 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг:

Дарга:  
А.Гантулга

-Байгаль орчны газрын дарга

Нарийн бичгийн дарга:  
Н.Сүх-Ялалт

-Байгаль орчны газрын Газрын хэвлий, түүний баялагийн ашиглалт, нөхөн сэргээлт, Газарзүйн мэдээллийн систем хариуцсан мэргэжилтэн

Гишүүн:  
Х.Энххэрлэн

-Байгаль орчны газрын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

С.Урантогос

-Байгаль орчны газрын Орчны бохирдол, химийн бодис хариуцсан мэргэжилтэн

И.Алтмаа

-Онон, Улз голын сав газрын захиргааны мэргэжилтэн

Ю.Мөнхтөмөр

-Дашбалбар сумын Байгаль хамгаалагч

Б.Цогтсайхан

-Дашбалбар сумын 1 дүгээр багийн Засаг дарга

Хүлээн зөвшөөрсөн: "Шинь шинь" ХХК-ийн төлөөлөл

Dai Shi Wu

